

I. ЕРӨНХИЙ ХАНДЛАГА

Монгол улсын төрийн одоогийн тогтолцоо нь 1992 оны шинэ Үндсэн Хууль, түүнд оруулсан өөрчлөлтүүд болон, тэдгээрийн үндсэн дээр баталсан хууль, эрх зүйн актуудаар тодорхойлогдож байна.

Төрийн тогтолцоо, үйл ажиллагаа нь үндсэн зарчим, утга агуулгаараа өмнөх нийгмийн байгууллын үеийнхээс эрс ялгаатай, ардчилсан нийгмийн амьдралын зохицуулалтад нийцэж байнга төгөлдөржин хөгжих шаардлагатай бойжилтын үедээ оршиж байна. Ийм болохоор ололт амжилтын зэрэгцээ хууль тогтоомж, нийгмийн сэтгэл, хүлээлтээс гажсан үйлдэл, арга барилын зэрэгцээ шинэ тогтолцооны дархлаа тогтоогүй үеийн сул дорой байдал, эрх зүйн орчны төгс гүйцэд бус байдлыг явцуу бүлэг, хувь хүний ашиг сонирхол, амбицид ашиглах хандлага олонтаа гарах нь дамжиггүй.

Төр, түүний эрхийг баригч улс төрийн хүчнүүд сэргэг мэдрэмжтэй, хариуцлагатай байж дээрхи гажуудлын учир шалтгааныг олж, олон түмний итгэл үнэмшил, дэмжлэгт тулгуурлан засаж зохицуулж чадвал төр бэхжин, нэр төр нь дээшилж, төрийн үйлчилгээ нь улс орны хөгжлийн нэгэн хүчирхэг үндэс болно. Харин ардчилсан төрийн зарчмуудаас гажсан, ухарсан үйлдлүүдийг төр өөрөө төрүүлж хамгаалах болон нийгмийн шаардлагад сохор дүлий хандаж хугацаа алдаж сөрөг үзэгдлүүдийг даамжруулан хуримтлуулбал төр олон түмнээсээ тасарч улс орон доройтолд орж, бухимдал хуримтлагдан урьдчилан таамаглахад бэрх үр дагаварт ч хүргэж болно.

Монгол орны одоогийн байдал эдгээр хандлагын аль алиныг агуулж байгаа боловч сүүлийн 5-6 жилд зарим чиглэлээр хоёр дахь хандлага хүчтэй болж, олон түмний анхаарлын төвд орж байна.



II. НИЙГМИЙГ БУХИМДУУЛЖ БУЙ ГАЖУУДЛУУД

Төр бол нийгмийн цогц нэгдэхүүн чанараас урган гарах одоо ирээдүйн асуудлыг бүх нийтийн эрх ашгийн үүднээс урьдчилан харж, оновчтой зохицуулан шийдвэрлэх төв юм. Ийм учраас ардчилсан нийгэмд олон түмэн төрийн бодлого, үйл ажиллагаанд тодорхой шаардлага тавьж, цаг үе бүхэнд үйл явдлын өрнөлийг өөрийн шалгуураар үнэлдэг.

Одоогийн байдлаар төрийн чанарын талаарх нийгмийн санаа бодолд хамгийн хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдлүүд болон үзэгдлийг дараахь байдлаар томъёолж болно гэж үзэж байна. Үүнд:

II.1. Төрийн албанд хээл хахууль, авилгал хавтгайрч, төрийн ялзрал доройтол илэрхий болж байна. Монгол улс авилгалын түвшнийг судалсан олон улсын байгууллагуудын үнэлгээгээр жил дараалан их авилгалтай орнуудын эгнээнд орж ирэв. Удаа дараагийн Ерөнхийлөгчид, УИХ-ын дарга, Ерөнхий сайдууд УИХ-ын чуулганд хандаж хэлсэн үгэндээ энэ асуудлыг хурцаар хөндөж байв. Гэвч төрөөс авилгатай тэмцэх үйл ажиллагаа одоо хүртэл хэлбэр төдий явж ирснээс гадна, “Гаалийн даргын”, “Танлуугийн”, “8 вагон самрын” гэх дуулиант хэрэг оромдох төдий шийдэгдсэн нь олон нийтэд таалагдсангүй.

II.2. ХЗХ-д бөөнөөрөө дампууралд орж олон арван мянган иргэдийн үлэмж мөнгийг үрсэн хэргийг анхнаас нь болхи мулгуу шийдэхийг оролдсон ч тэр нь дуусаагүй, “Санхүүжилтийн хорооны даргын амь насыг бүрэлгэсэн хэрэг” шүүгдээгүй байхад төрийн өмчид байсан “Хадгаламж банк”-аас 14.2 тэрбум төгрөг завшин луйвардсан хэрэг илэрчээ. Энэ нь төрийн хууль, хуулиа хэрэгжүүлэх чадварт эргэлзэх бодитой үндэс болж байгаа бөгөөд дээрх хэргүүдэд төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрийн хүчний идэвхтэнүүд холбогдолтой байж болзошгүй тухай хууль хяналтын байгууллагын ажилтнууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээлж байгаа боловч, нэрсийг нь “мөрдөн байцаалтын нууц” хэмээн халхалж байгаа нь төрийн нэр төрийг улам сэвтүүлж байна.

II.3. УИХ 1999 оны 12-р сард Үндсэн хуульд өөрчлөлт оруулах дэг журмын талаарх Үндсэн хуулийн 68-р зүйлийн заалтыг илэрхий зөрчин 20 минутын дотор зарчмын өөрчлөлт оруулсныг МУ-ын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн Цэц эсэргүүцсээр байтал 2000 оны сонгуулийн дараа хүчлэн баталж, төрийн тогтолцоог будлиулан төр нь Үндсэн хуулиа хөсөрдүүлэв. Түүнээс хойш Үндсэн хууль зөрчих явдал олонтаа гарч, үнэн хэрэгтээ

УИХ-ын гишүүд тангаргаасаа няцаж байгаа нь олонтаа тогтоогдож, эцсийн дүнд УИХ-ын дарга нь Үндсэн хууль зөрчиж УИХ-ын бүрэн эрхэд халдсаныг Цэц тогтоов. Төрийн дээд түвшинд Үндсэн хуульд эрээ цээргүй халдаж, зөрчиж байхад бусад хуулийн хэрэгжилтэд түүнээс өөрийг хүлээх боломжгүй. Төр нь хуулиа зөрчдөг нийгэмд ардчиллын тогтолцоо ч, иргэний аюулгүй байдал ч баталгаагүй. УИХ Үндсэн хуулийг зөрчсөн тухай бүрдээ Үндсэн хуулийн цэцэд өширхөн заналхийж, бүтэц бүрэлдэхүүн, удирдлагыг нь солино хэмээн дарамтлах нь зуршил болжээ. Одоогийн УИХ хэмжээгүй эрхт олонхийн диктатур тогтоож байна.

II.4. Улсынхаа нутаг дэвсгэрийн талаас илүү хувийг ашигт малтмалын лицензээр гадаад, дотоодын бизнес эрхлэгчдэд “эзэмшүүлж”, лицензийн наймаа төрийн хараа хяналтаас гарч, хил даван одсон нь нийт иргэдийн сэтгэлийг бухимдуулж байна. Төр Үндсэн хуулийн 6-р зүйлийн 2-р заалтад “...газрын хэвлий, түүний баялаг... төрийн өмч мөн” гэж заасныг зөрчиж, өмчийн эзний үүргээ биелүүлсэнгүй.

II.5. Улс төрийн зүтгэлтэн С. Зоригийн амь насыг бүрэлгэсэн гэмт хэргийн үйлдэгч, захиалагчдыг бараг 10 жил өнгөрч байхад илрүүлж чадсангүй. Төрийн албан хаагчын амь насыг ажлын байранд нь хөнөөсөн хэрэг гарав. Харгис хэрцгий гэмт хэрэг олонтаа гарах болж, эцэг эх, эхнэр нөхөр, үр хүүхдээ алж хороох гэмт хэргийн давтамж түргэсч байна.

Төрөөс ийм байдалд оновчтой хариу өгч, урьдчилан сэргийлж, гэмт хэргийг бууруулж чадахгүй байна.

II.6. Төрийн өндөр албан хаагчдын ёс зүй, ёс суртахуун доройтож, үндэснийхээ ариун нандин ёс заншлаас холдож байна. 2005, 2006 онд УИХ-аар Засгийн газрын тухай асуудал хэлэлцэх үед УИХ-ын гишүүд бүдүүлэг хэрүүл хийж, идэж ууснаа дэлгэлцэж, сайдууд зодолдон, бие биенээ заналхийж, тэр бүхнийг “эр хүмүүсийн дунд байдаг” харилцааны хэв хэмжээ болгон нийгэмд ухуулж байна. Ажилтныхаа чихийг тас хазсан дунд тушаалын дарга албаа хашсаар л байна. Өөрсдийгөө “эрхэм гишүүн” хэмээн өргөмжилсөн УИХ-ын зарим гишүүдийн хувьд төрийн ёс зүйн хог шаар болон одож буй Анпилов, Жириновскийн бүдүүлэг араншин, эрээ цээргүй муйхарлал хэвийн хэм хэмжээ болж, түүгээрээ “шударга”, “зоригтой” гэсэн нэр цол олохыг хичээх болсон нь төрт ёсны одоогийн нэг эмгэнэл юм. Төрийн өндөр албан тушаалтнууд морь мал уралдуулан мөрийцөж, мөрийтэй тоглоом хөөцөлдөн, хөрөнгө чинээгээрээ хээнцэрлэх болсон нь Монгол төрийн уламжлалт ёс, төр нь олон түмэндээ үйлчлэх зарчимд нийцэхгүй.

II.7. Төр засагт томоохон бизнесийн бүлэглэл, том хөрөнгөтний нөлөө давамгайлах болж, төрийн бодлого, үйл ажиллагаа тэдний эрх ашигт үйлчилж байна. Ийм хандлага Татварын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, сонгон шалгаруулалтгүйгээр дэд бүтийн объектын барилга байгууламж

захиалах тухай хууль боловсруулан хэлэлцэн батлах үед тодорхой илрэв. Түүгээр ч барахгүй УИХ, Засгийн газрын гишүүд төсвийн болон зээлийн хөрөнгө оруулалтыг өөрсдийн компанид өрсөлдөөнгүйгээр авах, тендерийг будлиулж хөрөнгө завших нь хавтгайрч байна.

II.8. Төр улам бүр үрэлгэн болж, сүүлийн зургаан жил төсвийн зардал 3.3 дахин өсч, төсвийн мөнгийг олигарх бүлэглэлүүдийн эрх ашигт нийцүүлэн хуваарилах явдал гарч байна. Түүгээр ч барахгүй УИХ-ын гишүүд тус бүр 2006 онд 100 сая төгрөг авч амтшаад, 2007 онд 250 сая төгрөгийг тойргууддаа хуваарилуулан, зарцуулах захиалгыг дур мэдэн өгч Үндсэн хуулиа зөрчсөнийг Үндсэн хуулийн Цэц тогтоов. Энэ нь Улсын төсвийн хөрөнгийг УИХ-ын гишүүдийн сонгуулийн өмнөх улс төрийн зорилгод ашиглах гэсэн оролдлого болж байсан бөгөөд засаглалын хуваарь, чиг үүргийг будлиулснаараа цаашдын гүнзгий уршигтай байж болох байв.

II.9. Шүүхийн үйл ажиллагаа олон тохиолдолд эргэлзээ төрүүлж, хээл хахууль, авилгалын талбар боллоо гэсэн дүгнэлтэд хүрснийг нэг биш судалгаа харуулж байна. Сүүлийн жилүүдэд шүүхийн хурлыг шоронгийн хашаанд явуулдаг зуршил тогтож байгаа төдийгүй саяхан ХЗХ-ны асуудлыг хохирогчгүйгээр хэлэлцэх оролдлого хийсэн нь шүүхийн шударга, хараат бус байх зарчимд эргэлзээ төрүүлж байна.

II.10. Нийгэмд баян ядуугийн ялгарал улам хүчтэй болж, ядуурлын түвшин буурахгүй байна. Сүүлийн 10 гаруй жилд зөвхөн АХБ-аас ядуурлыг бууруулахад 66 сая ам. доллар авч зарцуулсан боловч ахиц гарсангүй. Төрөөс цалин, тэтгэвэр тэтгэмж нэхэх шийдвэр гаргаж байгаа боловч ил, далд инфляци түүнээс түрүүлж байна. Ийм байдал төрийн бодлого зохицуулалтын чанарын түвшинг илэрхийлнэ.

II.11. Төрийн бодлогын мохоо сул, зохицуулалтын үр нөлөө дорой байдал нь байгаль, хүрээлэн байгаа орчны асуудалд хурцаар илэрч байна. 1990-ээд оны дунд үеэс ой мод, ан амьтны нөөцийг хайр гамгүй сүйтгэж, сүүлийн жилүүдэд уул уурхайн үйл ажиллагааны зөрчлийн улмаас хөрс, ус бохирдон сүйдэх нь үлэмж нэмэгдэв. Улаанбаатар хотын агаарын бохирдол орчны сүйрлийн хэмжээнд хүрч, нийт хүн амын 40%-ийн эрүүл мэндэд аюул учирч байна.

II.12. Төрийн сонгууль үнэн бодит мэдээллийн орчинд явагдахаас илүү хөрөнгө мөнгөний түрэлт, худал үнэн нь үл ялгарах хар цагаан PR-ийн нөлөөн дор явагдаж байна. Улс төрийн намууд сонгуульд оролцох эрхийг ч, сонгуульд бус төрийн албан тушаалыг ч хандив мөнгөөр үнэлдэг болсон нь нийтэд илэрхий. Ийм байдал бүх шатны сонгуулийн үр дүнд нөлөөлөөд зогсохгүй, төрд ашиг хонжоо, харилцааны сэтгэхүйд хөтлөгдсөн тохиолдлын хүмүүс орж ирэх бололцоо нээж, төрийн чанар, нэр хүндийг унагаж байна.

II.13. Төрийн үйл ажиллагаанд улс төрийн намын оролцоо хүчтэй болж, сонгуулийн мөрийн хөтөлбөрийн биелэлтийг УИХ-ын гишүүдээсээ шаардахаас хэтэрч, төр засгийн тогтолцоог зохицуулах, сонгуульд олонх суудал авсан тохиолдолд намын дарга нь МУ-ын Ерөнхийлөгчөөс давж, Ерөнхий сайдыг УИХ-д оруулах эрхтэй болсон нь улс төрийн төвөгтэй байдал үүсгэж байгаа билээ. Түүгээр ч барахгүй зарим нам дүрэмдээ Засгийн газар байгуулах эрх авсан тохиолдолд намын дарга нь Ерөнхий сайд болно хэмээн заасан нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд халдсан асуудал мөн. Энэ бүх эрхийг улс төрийн нам эдлэхдээ өөрийн дотоод зөрчил, санхүүжилтийн булхайг төрд нялзаан халдварлуулж байгаа нь бодит үнэн юм.

II.14. Засгийн газарт тогтворгүй байдал нүүрлэж, улс төрийн панз наймаагаар түүнийг байгуулж, төр засгийн нэр хүндийг улам унагаж байна. Төр засгийн тогтвортой

байдлыг хангах нэрээр намуудын хооронд байгуулсан эвсэл, хамтын ажиллагааны гэрээ нь улс төрчдийн хуйвалдааны халхавч төдий болжээ. Засаглалын хуваарь алдагдаж, УИХ-ын гишүүд төрийн сайдаар давхар ажиллах боломж нээгдсэн нь сайдын суудлын төлөө тэмцлийг бизнесийн арилжаа, өрсөлдөөний түвшинд буулгажээ.

II.15. Төрийн зохицуулалтад төвлөрөл нэмэгдэж, нутгийн өөрөө удирдах тогтолцоо сулран, нутгийн захиргаа, өөрийн удирдлагын байгууллагууд нийгэм-эдийн засгийн асуудлаа шийдэхийн тулд сонгуулийн өрсөлдөөн утга учиргүй улс төрийн талцлын барьцаа болж байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтад УИХ-ын гишүүдийн оролцоо нэмэгдэхийн хэрээр нутгийн удирдлагын хариуцлага суларч, хөрөнгө оруулалт нь сонгуулийн сурталчилгааны агуулгатай болж байгааг 250 саяын асуудал тод харууллаа.

III. ГАЖУУДЛЫН ҮНДЭС

Өмнө өгүүлсэн 15 зүйл гажуудал, доголдол нь улс орны ардчилсан замналын хөгжил төрүүлэх боломжийг сулруулж, нийгэмд бухимдал төрүүлэх гол эх сурвалж болж байгааг хэн ч үгүйсгэхгүй биз. Энд нийгэм, эдийн засаг, улс төр, зан суртахууны олон хүчин зүйлс сүлбэлдэн нөлөөлж байгаа ч гэсэн чухамхүү төр л нийгмийн амьдралын зохицуулалт жолоодлогын төлөө хариуцлага хүлээх талаас нь хандвал учгийг тайлж болох юм.

Нийгмийн амьдралд учирч буй төвөгтэй асуудлуудыг төрийн талаас дараахь хоёр чиглэлээр авч үзэж болно. Үүнд:


III.1. ТӨРИЙН БҮРДЭЛ

Алив төрийн оршин тогтнох ахуй буюу бүрдэл нь:

1. Төрийн институт
2. Төрийн хууль, дүрэм
3. Төрийн хүн байдаг.

Төрийн чиг үүрэг тус бүрээр энэ гурван нөхцөл цогцлон бүрдсэн тохиолдолд л төр үүргээ хэрэгжүүлж чадна. Ийм учраас төр бол конъюнктив систем юм.

Өөрөөр хэлбэл, төрийн чанар буюу үүргээ биелүүлэх чадварын дэд хязгаар нь дээрх бүрдлүүдийн чанарын хамгийн бага утгаар тодорхойлогдоно. (Зур 1).



Зур 1. Төрийн чанар бүрдлээс хамаарах нь


Монгол орны одоогийн нөхцөлд төрийн үйл ажиллагааны чанарыг тодорхойлж байгаа §2-д тоочсон үзэгдлүүдийг төрийн бүрдлийн

чанартай холбон дараахь байдлаар ангилж болох байна. Үүнд:

Сөрөг үзэгдлүүд	Хүчин зүйлс	
	Анхдагч	Төрийн бүрдлийн чанарт холбогдох нь
2.1. Хээл хахууль, авилга дэлгэрэв	Хяналтгүй байдал, УТ-ийн хүчний санхүүжилт	X ₁ , X ₂ , X ₃
2.2. ХЗХ, Хадгаламжийн банкны хэрэг	Хууль согогтой, хяналт сул	X ₁
2.3. Үндсэн хууль, хуулийн зөрчил	Ашиг сонирхол, мэдлэг чадвар дутмаг	X ₁ , X ₃
2.4. Ашигт малтмалын лиценз хавтгайрсан	Хяналтгүй.	X ₁ , X ₃
2.5. Хүнд ноцтой гэмт хэргүүд	Нийгмийн стресс, зан суртахууны доройтол	X ₃
2.6. Төр ёс алдарч байна.	Албан тушаал, ашиг сонирхлын наймаа	X ₃
2.7. Олигархийн ноёрхол	Сонгууль зөвхөн хөрөнгөлөг хүмүүст боломж олгодог.	X ₁
2.8. Төр үрэлгэн	Сонгуулийн амлалт, PR	X ₁
2.9. Шүүх засаглал	Захиалгат шийдэл, авилга	X ₃
2.10. Нийгмийн ялгарал, ядуурал	Төрийн бодлого сул	X ₃
2.11. Төрийн бодлого холч бус /байгаль орчин, хотын агаар/	Төр чадварлаг бус, төрийн бодлого програмт удирдлагын түвшинд хүрээгүй	X ₃
2.12. Төрийн сонгууль мөнгөөр шийдэгддэг болов.	Намууд өрсөлдөх эрх, төрийн албыг худалддаг.	X ₃
2.13. Төрд намын ноёрхол сэргэв.	Намууд төлөвшөөгүй, ашиг сонирхлын бүлэг	X ₂ , X ₃
2.14. Засгийн газар тогтворгүй	Намууд, ашиг сонирхлын бүлгийн өрсөлдөөн	X ₂
2.15. Нутгийн өөрөө удирдах ёс суларч, төвлөрөл нэмэгдэж байна.	Төвлөрсөн зохицуулалтын инерц	X ₂

Үүнээс үзвэл, нийгэм-улс төрийн тогтолцоонд илэрч буй сөрөг хандлагын эх сурвалж нь

төрийн бүрдлийн хүчин зүйлийн талаас дээрх бүтэцтэй байна.



Ийнхүү аль нэг хүчин зүйлээс дагнасан хамааралтай үзэгдлийн бүтэц нь нийт хамааралтай ойролцоо байгаа бөгөөд дүнгээрээ

55% (11/ 20)-ийг эзэлж байна. Харин цогц хамаарлын бүтэц нэлээд өөр ажээ. Тухайлбал:

№	Цогцууд	Давтамж
1.	Гурван хүчин зүйлийн цогц ($X_{\text{төр}} \rightarrow X_1, X_2, X_3$)	2
2.	Хоёр хүчин зүйлийн цогц	3
	- Хууль, хүний хүчин зүйлсийн ($X_{\text{төр}} \rightarrow X_1 \cup X_3$)	2
	- Хууль, зохион байгуулалтын ($X_{\text{төр}} \rightarrow X_1 \cup X_2$)	0
	- Зохион байгуулалт, хүний хүчин зүйлсийн ($X_{\text{төр}} \rightarrow X_2 \cup X_3$)	1

Эдгээр байдлыг харгалзвал гурван хүчин зүйлийн цогцоос хамаарах 2.1 асуудал (хээл хахууль, авилга) хамгийн их хүчин чармайлт, шинэлэг шийдэл шаардана.

Тэгэхдээ энэ нь хүчин зүйлүүд дагнасан буюу хосолсон асуудлыг хялбарчилж буй хэрэг бус бөгөөд хүчин чармайлтын чиглэлийг тодруулах төдий л юм. Учир нь төрийн бүрдлийн дээрх гурван хүчин зүйл бүтэцлэг чанартай. Тухайлбал:

1. Хууль тогтоомжтой холбоотой асуудал:

- 1.1. Хуулийн зохицуулалтгүй
- 1.2. Хуулийн заалтууд зөрчилтэй
- 1.3. Хуулийн зохицуулалт оновчтой бус
- 1.4. Хууль хэрэгжих механизмгүй

2. Зохион байгуулалтын хүчин зүйлтэй холбоотой асуудал:

2. 1. Чиг үүрэг орхигдсон, эзэнгүйдсэн
2. 2. Үүрэг хариуцлага холилдсон
2. 3. Хэврэг найдваргүй зохион байгуулалт сонгосон
2. 4. Хараат байдалд орсон

3. Төрийн хүний чанартай холбоотой асуудал:

3. 1. Мэргэжил, ур чадвар дутсан
3. 2. Зүтгэл, эрсдэл хүлээх чадвар сул
3. 3. Ёс суртахуун, ёс зүйн доголдол
3. 4. Ашиг сонирхлын зөрчилд автсан
3. 5. Хараат байдалд орсон

зэрэг хүчин зүйлээс шалтгаалдаг. Жишээлбэл, хээл хахууль, авилгын асуудал төрийн хүний чанартай холбогдох утгаараа хувь хүний ашиг сонирхол (шунал), ёс суртахуун, далд хамаарал (улс төрийн хүчинд хандив сан цуглуулж албан тушаалд үлдэх буюу дэвшил болзол)-тай шүтэлцэнэ.

Түүнчлэн тэр нь зохион байгуулалтын асуудалд холбогдох утгаараа хяналт, сорилтын чиг үүрэг орхигдсон, авилгатай тэмцэх үүрэг олон субъектын дүнд хөсөрдсөн, төрийн албыг ашиг сонирхлын бүлэг, улс төрийн нам өмчилсөн байдлаас хамаарна.

Харин хууль, тогтоомжтой холбогдох утгаараа цээрлэл хөнгөдсөн (төр, нийгэмд учирсан хохирлыг төлүүлдэггүйгээс ял эдэлсний дараа баян цатгалан амьдрах боломжтой), гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх боломж олон янзын өмгөөлөл, дархлаагаар хязгаарлагдсан, мэдээллийг хянах шалгах боломж хаагдмал байдлаас үүсдэгийг сүүлийн жилүүдийн дуулиант асуудлууд тод харуулж байгаа билээ.

Энэ мэтчилэн төрийн үйл ажиллагаатай холбоотой дээрх 15 үзэгдлийг нэг бүрчлэн шинжилж төрийн бүрдлийн дэд хүчин зүйлсээр ангилбал 39 зүйлд холбогдоно. Тэдгээрийг дэд зүйлсээр ангилбал:

		Холбогдох асуудал	
		Тоо	Дүнд эзлэх %
1.	Хууль	8 → 13	36. 6 → 33. 3
	1. 1	1	7.7
	1. 2	2	15.4
	1. 3	8	61.5
	1. 4	2	15.4
2.	Зохион байгуулалт	5 → 9	22.7 → 23.1
	2. 1	2	22.2
	2. 2	2	22.2
	2. 3	1	11.1
	2. 4	4	44.5
3.	Төрийн хүн	9 → 17	40. 9 → 43.6
	3. 1	4	23.5
	3. 2	1	5.9
	3. 3	2	11.7
	3. 4	8	47.1
	3. 5	2	11.7

Эндээс төр, нийгэмд тулгарч байгаа асуудлуудад ямар хүчин зүйл, ямар хүчээр нөлөөлж байгааг оношилж болох юм.

Хууль тогтоомжтой холбоотой асуудлуудад хуулийн оновчтой бус шийдэл (61.5%), зохион байгуулалтын хүрээнд хараат байдал (44.5%), төрийн хүний хүчин зүйлийн хүрээнд ашиг сонирхлын зөрчил (47.1%) тэргүүлэх байр эзэлж бусад хүчин зүйлс дараалж байна. Хэрэв хууль ч, төрийн зохион байгуулалт ч хүний бүтээл байдаг талаас нь хандвал хууль тогтоогчдын чанар, засаг явуулагчдын чанарын тухай л асуудал үлдэх болно.

III.2. ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛХЭЭ

A. Онолын зарчмууд

Төрийн чиг үүрэг тус бүрээр явуулах үйл ажиллагаа, улмаар төрийн албадын үйл ажиллагаа нь нийгмийн амьдрал, түүний жолоодлогын ерөнхий зүй тогтолд нийцсэн бүтцийг олсон тохиолдолд л тогтвортой, чанартай болдог.


Энэхүү бүтэц нь:

- мэдээлэл авах
- шинжилж төлөвлөх
- шийдвэр гаргах
- хэрэгжүүлэх
- хэрэгжилтийг хянаж, зохицуулах, хөтөлбөрийг сайжруулах үе шатаас бүрддэг.

Тэгэхдээ эдгээр үе шат нь зөвхөн дараалсан алхамууд төдий бус, хоорондоо улс орны хувь заяаг залах, шийдэх их үйлсийн түүх, түүний ухаарлаар хуримтлагдсан мэдлэг, арга туршлагын өв санд тулгуурласан зүй тогтол бүхий нарийн төвөгтэй холбоо хамаарал, шүтэлцээтэй байдаг. Үүнээс одоогийн манай орны нөхцөлд хамаарах гол зарчмууд нь:


1. Найдваргүй, тогтворгүй, хүч сул элементүүдээс найдвартай, тогтвортой, хүчтэй систем бүрдүүлэх нь жолоодлогын үндсэн зарчим юм. Энэ утгаар нь хүчтэй төр бол хүчтэй удирдагчид төдий бус хүчтэй тогтолцоонд түшиглэдэг билээ. Төрд ажиллаж буй ямар ч хүн, төрийн ямар ч алба дангаараа төгс шаардлага хангадаггүй. Ийм нөхцөлд зөв зохион байгуулалтаар тэдгээр элементээс илүү өндөр чанартай систем ч бүрдүүлж болно. Эсвэл улам дордуулж ч болно. Энэ талаар залуур зүйн онолд өгүүлэх нь:

A) Тус бүрдээ найдвартай ажиллагааны магадлал нь P_i ($1 \geq P_i \geq 0$) элементүүдийг угсруулан холбовол нийт системийн магадлал нь $P = \prod P_i$ болж доройтно:



Өөрөөр хэлбэл, удирдлагын шат дамжлага олшроход түүний үйл ажиллагааны чанар нь зэрэг дэвшүүлсэн хурдаар буурна.

Б). Тус бүрдээ найдвартай ажиллагааны магадлал нь P_i элементүүдийг харилцан орлож нөхөхөөр холбовол нийт системийн магадлал нь $P=1-\prod_i (1-P_i)$ болж нэмэгдэнэ.




Энэ зарчмыг монголчууд “бүгдээрээ хэлэлцвэл буруугүй” хэмээн томъёолж, амьдралд хэрэгжүүлдэг билээ.

В) Найдвартай ажиллагааны P_1 магадлалтай элементэд өөрийн үйл ажиллагааг хянаж, өөрийг P_2 магадлалтайгаар өөрчлөх чадвартай элемент нэмбэл нийт системийн үйл ажиллагаа нь буцах холбооны хуулиар


$$P = \frac{P_1}{1 - P_1 P_2} \text{ болж дээшилнэ.}$$

Монголчууд энэ зарчмыг “өдрийн явдлаа шөнөд нь өнөөдрийн явдлаа маргааш нь шүүж тунгаах” хэмээдэг билээ.




Төр, нийгмийг удирдахад амин чухал эдгээр зарчмууд нь төрийн албад, төрийн хүмүүсийн үйл ажиллагааны “хэлхээг” бүрдүүлэхэд улс нийгмийн хөгжлийн түвшин, төр баригчдын ур чадвар, төр нийгмийн байгууллаас хамааран олон хэлбэрээр хэрэгжих боловч нийтлэг агуулгаа хадгалж чадсан хэр хэмжээгээр төрийн ажиллагааны чанар тодорхойлогддог.

Дээрх зарчмуудыг цогцлуулан хэрэглэсэн тохиолдолд төрийн үйл ажиллагааны хэлхээг дараахь байдлаар бүдүүвчлэн илэрхийлж болно:



2. Удирдлагын субъект нь удирдлагын объектын орших огторгуйг бүрэн багтааж үйлчлэх чадвартай нөхцөлд үйл явдлыг хянаж, жолоодож, удирдаж, зохицуулж болно.



Энэ зарчим нь төр, түүний албад, төрийн хүмүүсийн чанар, үйл ажиллагааны цар хүрээнд тавих үндсэн шаардлагыг тодорхойлно.

Өөрөөр хэлбэл, удирдлагын субъект нь удирдлагын объектод нөлөөлж буй гаднын хүчин зүйлсийг эсвэл тэдгээрийн үр дагаврыг хязгаарлах, залж жолоодох, тэвчиж туулах боломжтой нөхцөлд л удирдлага хэрэгжинэ. Гэтэл, удирдлагын объектод нөлөөлж буй хүчин зүйлс ихэнх тохиолдолд санамсаргүй үзэгдлийн шинжтэй байхаас гадна, түүний хүчийг бүрэн залж жолоодох боломжгүй байх нь олонтаа. Тэгээд ч нийгмийн хүрээнд удирдлагыг хүн хэрэгжүүлэх тул тэдий мэдлэг чадварын дээд хэмжээнд тэмүүлэх боловч байгалиас заяасан чадвар нь хязгаарлагдмал билээ. Боломжийн авьяаслаг удирдагч хүн 3-4 хүчин зүйлийн үйлчлэлийг хянаж, зөв шийдвэр гаргах


чадвартай байдаг бол суут жолоодогчид нэгэн зэрэг долоон хүчин зүйлийг хянаж чаддаг.

Ийм болохоор нийгмийн хүрээний удирдлагыг хэрэгжүүлэхэд удирдлагыг удирдлагын объектын үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн, удирдлагын субъектыг шаталж зохион байгуулах шаардлага зайлшгүй төрнө.

Энэхүү шатууд нь субординацийн хуулиар дээд шатандаа нэгдэн захирагдаж эцсийн дүнд нэгдмэл нэг субъект бүрдэнэ.

3. Удирдлагын үйл ажиллагааны бүтэц, мөн чанар түүнийг хэрэгжүүлэгч субъектын хөгжил, объектод нөлөөлж буй хүчин зүйлсийн хүч, шинж төлөв, орчин нөхцлөөс хамаарч дараах хэвшлийн аль нэгний давамгайлсан шинжийг агуулна. Үүнд:


3.1. Удирдлагын объектод нөлөөлж буй хүчин зүйлсийн хувиралт, өөрчлөлтийг удирдлагын субъект нь урьдчилан мэдрэхгүйгээр түүний сөрөг үр дагаврыг ($y-y_0$) гэтлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг тогтолцоог нөхвөрлөх удирдлага гэдэг.




Удирдлагын энэ хэвшил байгаль, цаг уурын үзэгдэл, дэлхий нутгийг хамарсан хямрал зэрэг “үл давтагдах” хүчин зүйлс нөлөөлсөн үед зайлшгүй боловч төр нь улс орноо жолоодох чадвар сул үед олонтаа тохиолддог.

3.2. Гадны хүчин зүйлсийн нөлөө нь удирдлагын объектын дотоод хувиргалт буюу оршихуйн хууль, хөдөлгөөний дүрмийг өөрчилдөг. Энэ тохиолдолд удирдлагын субъект нь объектынхоо амьдрах чадварыг сэргээхийн тулд объектын төдийгүй өөрийн параметрийг өөрчлөх шаардлага гарна. Ингэж хэрэгжих удирдлагыг зохицох удирдлага гэдэг.

Энэ бол удирдлагын субъект нь объектын оршихуйн хуулийг өөрчлөх чадвартай болсноос гадна, өөрийгөө өөрчлөн хөгжүүлэх (Ф) бүтэцтэй болж орчиндоо дасан зохицох чанарыг олохтой холбоотой. Алив хувьсал, хөгжил удирдлагын зохицох хэвшлээс эхэлдэг.




3.3. Гадны хүчин зүйлсийн өөрчлөлтийг урьдчилан зөгнөж, удирдлагын объектын хувьсалт өөрчлөлтийн ашигтай зам мөрийг холчоор тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх удирдлагыг програмт удирдлага гэдэг.



Удирдлагын энэ хэвшил сүүлийн 50-иад жилд өргөн дэлгэрч хөгжил дэвшилд төрийн гүйцэтгэх үүргийн гол шалгуур болж байна. Удирдлага (F)-ыг программчлах П-блок нь системийн зам мөрийн үйл явдлын өөрчлөлтийн янз бүрийн хувилбараар тооцож, программын хэрэгжилтийг хамгийн их магадлалтайгаар хэрэгжүүлэх хүчийг бүрдүүлэх арга хэрэгслийг тодорхойлдог ороо онцлог юм.


3.4. Онцгой нөхцөл байдлын улмаас тодорхой болзол, зорилгыг биелүүлэх үүднээс удирдлагын объектыг нөөц бололцооны нь дээд хэмжээнд дайчлах буюу аюул занал, бэрхшээлийг доод хэмжээнд тогтоон барихад чиглэсэн удирдлагыг экстрем удирдлага гэнэ.



Экстрем удирдлагын нөхцөлд удирдлагын объектын даац (чадал)-ын дээд хэмжээг (y_{max})-г тодорхойлох L-блок онцгой хариуцлага хүлээх бөгөөд экстрем шийдвэр гаргах E- блок нь түүнийг x , y хувьсагчтай харьцуулан хянах боломжтой байна.

Удирдлагын энэ хэвшлийг нийгмийн хүрээнд байгалийн гамшиг, дайн байлдаан, аюул занал тулгарсан үед тодорхой хугацаагаар хэрэглэх боловч харгис дэглэмийн нөхцөлд урт удаан хугацаанд хэрэглэсэн тохиолдол цөөнгүй. Экстрем удирдлагыг урт удаан хугацаанд хэрэглэх нь нийгмийг бүхэлд нь гажуудалд хүргэдэг ажээ.


3.5. Хязгаарлагдмал нөөц бололцоог гадаад орчны өөрчлөлтийн нөхцөлд хамгийн үр ашигтай хэрэглэж, удирдлагын объектын үр өгөөжийг дээд хэмжээгээр тэтгэх удирдлагыг оновчтой удирдлага гэдэг.



Оновчтой удирдлагын хэвшил нийгмийн хүрээнд 50 хүрэхгүй жилийн настай. Удирдлагын энэ хэвшилд T, Q, O блокууд нэмэгдэж байгаа бөгөөд T-нь шинэ төрөл санааг туршиж, удирдлагын объектдоо: Δx , Δs цочрол үзүүлсний үр дүнг удирдлагын субъект (F)-д шинжилж шийдвэр гаргана. Тэгэхдээ гаднын хүчин зүйлс (x), объектын бодит байдал (y)-аас үүссэн хязгаарлалтыг (L) харгалзан оновчилсон (O) хувилбарыг үндэс болгоно. Орчин үед дэлхий нийтэд түгээмэл хэрэглэж байгаа даацтай (тогтвортой) хөгжлийн хөтөлбөрүүд тухайн үндэстний эрх ашиг, орчин нөхцөл, нөөц бололцоог цогц үнэлж, үндэстний зөвшилд хүрсэн утгаараа оновчтой удирдлагын жишээ болно.

4. Удирдлагын объектын тогтвортой байдал, хөдөлгөөний чанар нь зөвхөн гаднын хүчин зүйлээс төдийгүй, удирдлагын субъектын

чанар, зохицуулалтын хүчнээс хамаарна. Ийм учраас удирдлагын субъектын жолоодлогын утга нь объектын орчин, жолоодлого шингээх чадварт нийцэх ёстой. Шаардлагатай хэмжээнээс хэтэрсэн зохицуулалт удирдлагын объектыг учраа олохгүй цочроонд оруулж, үл тогтворжих, санамсаргүй савлагаанд хүргэдэг.



Ийм байдал нийгмийн хүрээнд аливаа хэт туйлшрал, удирдлагын ур чадваргүй байдал, ерөөсгөл хөрөнгө оруулалт зэргээс үүсч болно.

Б. Одоогийн тогтолцоог онолын зарчмаар үнэлэх нь

Манай орны төрийн тогтолцоо, үйл ажиллагаа, одоогийн зөрчилтэй байдлыг удирдлагын онолын дээрх зарчмуудын талаас үнэлбэл тулгарч байгаа бэрхшээлүүд ихэнх тохиолдолд тогтолцооны согогтой холбоотой гэж үзэж болох байна. Үүнд:

1. Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага нь УИХ бөгөөд дөрвөн жилд нэг удаа нэг мөчид сонгогддог билээ. Үндсэн хууль батлагдсанаас хойш дөрвөн удаагийн сонгууль болж, УИХ-ын улс төрийн бүтэц, гишүүдийн бүрэлдэхүүн тухай бүр огцом өөрчлөгдөж иржээ:

Сонгууль (оноор)	Улс төрийн бүтэц - %		Бие бүрэлдэхүүний бүтэц - %	
	МАХН	Бусад	Шинээр сонгогдогсод	Бизнес эрхлэгчид
1990-1992	60	40	100.0	-
1992	93.4	6.6	84.9	-
1996	92.9	67.1	77.7	9.1
2000	94.7	5.3	84.2	30.3
2004	50.0%	50.0%	80.3	39.5

Ийм байдал төрийн дээд түвшинд төрийн бодлого, ажлын зохион байгуулалт, арга технологийг тогтвортой төлөвшүүлж хэрэгжүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлж чадахгүй.

Өөрөөр хэлбэл, төрийн дээд байгууллага нь туршилт, сургуулилалтын талбар болж, баталж гаргаж байгаа хууль, шийдвэр нь ч ийм агуулгатай болж байна. Түүгээр ч барахгүй төрийн бодлогод эрх мэдэлтнүүдийн бизнесийн сонирхлоор хандах нөхцөл бүрдэж, улс төрийн орчныг бохирдуулж байгаа билээ.

УИХ-ын сонгуультай давхцан орон нутгийн сонгууль явагддаг. Энэ нь УИХ-ын бүтцэд гарсан долгионыг улс орон даяар түгээх түлхэц болох бөгөөд орон нутгийн ИТХ, захиргааны бүх шатны байгууллагуудын ажилтнуудын

хөдөлгөөн, халаа сэлгээ үүсгэдэг. Ингэснээр төрийн толгойд гарсан чичиргээ гажуудал бүх шатандаа дамждаг ажээ.

2. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд Монгол улсын Ерөнхийлөгч бол “Төрийн

тэргүүн мөн” гэж заагаад энэ үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүрэн эрхийг тодорхойлсон юм. Гэвч түүнээс хойш Ерөнхийлөгчөөс төрийн тэргүүний үүргээ гүйцэтгэх чадварыг бууруулах өөрчлөлт хийснийг нийтээр мэдэх билээ.

1992 оны үндсэн хуульд	Өөрчлөлтүүд	Өөрчлөлтийн утга, үр дагавар
<p>1. <i>Үндсэн хууль 33. 1. 2:</i></p> <p>”УИХ-д олонхи суудал авсан нам-тай, аль ч нам олонхийн суудал аваагүй бол УИХ-д суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг УИХ-д оруулах.</p>	<p>“Нэмэлт өөрчлөлт 2. 5. 2.</p> <p>... оны 12-р сарын 14-ний өөрчлөлт:</p> <p>“УИХ-д олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг аль ч нам эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол УИХ-д суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор УИХ-д оруулах”</p>	<p>1.1. МУ-ын Ерөнхийлөгч төрийн тэргүүний хувьд гүйцэтгэх засаглалын тэргүүнийг, томилоход ямар ч эрх мэдэлгүй болж, зөвхөн намын захиа зөөгч болов.</p> <p>1.2. Урьд нь төрийн тэргүүний үндсэн бүрэн эрхэд хамаарч байсан Ерөнхий сайдын томилгооны зөвшилцлийн эрхийг төрийн бус байгууллага болох намд өгөв.</p> <p>1.3. УИХ-д аль ч нам олонхи суудал аваагүй үед олон суудал авсан нам нь олонхиос давуу эрх эдлэх болов.</p> <p>1.4. Засгийн газрын үйл ажиллагаа бүхэлдээ намын атганд оров.</p> <p>1.5. Төрийн тогтолцоо өөрчлөгдөж, төрийг нам удирдах болов.</p>
<p>2. <i>Үндсэн хууль 39. 1. 2.</i></p> <p>МУ-ын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн УИХ-д өргөн мэдүүлнэ.</p>	<p><i>Нэмэлт өөрчлөлт 1. 2.</i></p> <p>“Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол УИХ-д өөрөө өргөн мэдүүлнэ.</p>	<p>1. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд Ерөнхийлөгчийн нөлөөлөх боломж хаагдав.</p> <p>2. Засгийн газар Ерөнхий сайдаараа дамжин намын хяналтад оров.</p> <p>3. Төрийн удирдлагын дээд түвшинд зөрчлийн үр тарив.</p>

1992 оны үндсэн хуульд	Өөрчлөлтүүд	Өөрчлөлтийн утга, үр дагавар
3. Үндсэн хууль 35. 2. “Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнхи олонхийн саналаар огцруулна”	Ерөнхийлөгчийн тухай хууль 7.2. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль, бусад хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг УИХ-ын нийт гишүүний 1/ 3-ээс доошгүй нь албан ёсоор тавибал Үндсэн хуулийн 35. 2-т заасны дагуу УИХ хэлэлцэж, Ерөнхийлөгчийг огцруулах эсэхийг шийдвэрлэнэ.	1. Үндсэн хуульд “Цэцийн дүгнэлтийг үндэслэн” гэж заасныг “УИХ-ын нийт гишүүний 1/ 3” хэмээн УИХ-д давуу эрх авч Ерөнхийлөгчид “хавх” тавьжээ. УИХ-д аль нэг нам олонхи суудал аваагүй нөхцөлд энэ “хавх” нь 33. 3%-иас дээш суудалтай улс төрийн хүч төрийг барьцаалан төрийн эргэлт хийх боломж олгоно.
4. Үндсэн хууль 22. 2. “Ерөнхийлөгч УИХ-ын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно.	УИХ-ын тухай хууль 31.1.2. Ерөнхийлөгч УИХ-ын даргатай зөвшилцөн санал нэгдэж, ... тараах төсөл өргөн мэдүүлснийг УИХ хэлэлцэж ёсоор болгосон.	1. УИХ нь тарахгүй гэвэл тарахгүй. 2. Үндсэн хуульд зөвшилцөн гэснийг санал нэгдвэл гэжээ. 3. Хэмжээлшгүй эрхтэй олонхийн ноёрхол тогтов.

Төр байгуулах үйлст төрийн тэргүүний эрхийг хязгаарлан, улс төрийн намыг төрд голлох үүрэгтэй болгосон нь намын удирдлага хэмээх эрх мэдэл, ашиг сонирхлын бүлэглэлийн шийдвэрийг бүх ард түмний сонголтоор сонгосон Ерөнхийлөгчид тулгаж байна.

3. Төрийн эрх барих дээд байгууллагуудаас эхлэн яам, агентлаг, нутгийн захиргааны бүх шатанд найдвартай ажиллагааны зарчим зөрчигдсөн зохион байгуулалт хэрэгжиж байна.

УИХ нэг танхимтай, 7 байнгын хороотой, 76 гишүүнтэй билээ. УИХ-ын гишүүд хоёр хүртэл

БХ-ны үйл ажиллагаанд оролцох эрхтэй бөгөөд БХ-ны шийдвэр нь УИХ-ын шийдвэрийн үндэс болдог. Энэ байдлаас улбаалаад нэг талаас сонгогчид, УИХ-ын гишүүдийг улс орны нийтлэг эрх ашгийг дээдлэхийн төлөө сонгосон сонголт нь Байнгын хорооны чиглэлийн явцуу хүрээнд үйл ажиллагаа явуулах сонголт болохоос гадна, нөгөө талаас БХ-ны цөөн хүнтэй (17-21) бүрэлдэхүүн нь улс төр, эдийн засгийн лобби бүлэглэлийн нөлөөнд автах магадлал ихтэй ажээ. Аль ч нам олонхи суудал аваагүй одоогийн нөхцөлд ч энэ зохион байгуулалтын сул тал нь УИХ-ын шийдвэр, хуулийн чанарт мэдэгдэхүйц нөлөөлж байна.

Тэгээд ч УИХ-ын гишүүдийн цөөнгүй нь чуулганы (нэгдсэн чуулган, БХ-ны хурал) үйл ажиллагаанд оролцохгүй өөрийн хувийн бизнесийн болон улс төрийн үйл ажиллагаанд ихэнх цагаа зориулдаг, зарим хэсэг нь бүрэн эрхийн хугацаанд амиа халхлан юу хэлэлцэж байгааг ч ойлгохгүй өнгөрдөг одоогийн нөхцөлд УИХ-д хэлэлцсэн асуудал БХ-ны олонхийн ирцтэй (9-11 хүн) хурлын олонхи буюу 5-6 хүний саналд үнэдэслэн УИХ-ын чуулганд 39 хүн оролцсон тохиолдолд 20 хүний саналаар шийдвэрлэх нь цөөнгүй болжээ. Ийм нөхцөлд чанартай хууль, шийдвэр гарах магадлал бага юм.

4. Засгийн газрын тухай одоогийн хуульд зааснаар авч үзвэл түүний дотоод чиг үүргийн хуваарь, зохион байгуулалтын бүтэц нь Үндсэн хуулиар тодорхойлсон чиг үүргийг биелүүлэх нөхцөлийг хангахгүй байна. Үүнд:

4.1. Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээ нь мэдээлэл, харилцаа холбоо, өндөр технологи, тагнуулын асуудлаар хязгаарлагджээ. Уг нь Ерөнхий сайдын үндсэн үүрэг нь Засгийн газрын үйл ажиллагааг улс орны хөгжил, нийгмийн амьдралын амин чухал асуудлууд дээр зангидаж, сайдуудын нэгдмэл, үр ашигтай, хариуцлагатай үйл ажиллагааг хангахад орших билээ. Гэтэл Худалдаа, үйлдвэрийн яамны үндсэн зорилт болсон өндөр технологийн асуудал, дэд бүтцийн нэг салбар болох мэдээлэл, харилцаа холбооны асуудлыг Ерөнхий сайдын үүрэг болгожээ.

4.2. Засгийн газарт Шадар сайд хэмээх сайдаас хэтийдсэн албан тушаал ажлын алба байхын утга учир нь салбар хоорондын зангилаа асуудал, ЗГ-ын шийдэх нэн чухал асуудал, шийдвэрийн биелэлтэд тавих хяналтын давхар буцах холбоо үүсгэж, Ерөнхий сайдад мэргэжлийн дэмжлэг үзүүлэхэд оршдог. Гэтэл одоогийн хуваариар бүс нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, оюуны өмч, стандартчилал, хэмжил зүй, шударга бус өрсөлдөөн, хүүхэд залуучуудын асуудал гэсэн салбарын сайдуудын эрхлэх асуудлуудаас хэлтэлж салгасан ажил үүрэг хариуцаж байгаа нь уг албан тушаалыг улс төрийн өөш болгосны илрэл гэлтэй.

4.3. Засгийн газрын гишүүдийн ажил үүргийн хуваарьт төрийн захиргааны төв байгууллагуудын ажлын зохион байгуулалт, ажлын арга технологи, хүний хөгжлийн асуудал огт тусгагдаагүй үлдсэн нь одоогийн хямралт байдлын нэг гол үндэс болж байна.

4.4. Засгийн газрын бүтцэд мэргэжлийн хяналтыг салбарын яамдаас салгаж яам зохион байгуулсан нь салбарын удирдлагыг гол буцах холбооноос салгаж, яамдын ажлыг өрөөсгөл хандлагад түлхэж байна.

5. Үндсэн хуульд төрийн албадын үйл ажиллагааны хяналт, төрийн жинхэнэ албан хаагчдыг бэлтгэх, шалгаруулах тогтолцоо, төрийн санхүүгийн засаглалын асуудал орхигджээ. Энэ нь Үндсэн хуулийн агуулга,

нийгэмд гүйцэтгэх үүрэгт социалист тогтолцооны сэтгэхүйгээр хандсаны үр дагавар байж болох юм. Гэвч зах зээлийн харилцаанд шилжиж, төр хувийн өмчтэй харьцаж орших болсон нөхцөлд Үндсэн хуулийн одоогийн бүтэц хангалтгүй нь улам тодорхой болж байна. Үүний улмаас одоогийн Төрийн хяналтын хороо, Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаа нь үр нөлөөтэй, цогц тогтолцооны чанар олж чадахгүй байна. Энэ нь төрийн албадад бэлтгэгдээгүй, явцуу сонирхолд хөтлөгдөн хүмүүс шургалах, төсвийн хөрөнгийг шударга бус, үр ашиггүй зарцуулах, авилга, хээл хахуульд өртөх боломж олгож байна.

Чухамхүү ийм байдлын улмаас Авилгатай тэмцэх газар тусгайлан байгуулж байгаа боловч тэр нь төрийн албыг чанартай, хариуцлагатай, шударга болгох зорилтыг цогц бүрэн шийдэж чадахгүй нь илэрхий.

6. Сонгуулийн тухай хууль болон Намын тухай хууль төрөө байгуулах ард түмний хүсэл зоригийг мөнгө хөрөнгөөр булингартуулж, намууд төрийн эрх мэдлийн төлөө өрсөлдөх эрх хийгээд төрийн албыг худалдах мухлаг болох хандлага улам бүр хүчтэй болох үүд хаалгыг чөлөөтэй нээж байна. Дээрх хуулиудад хориглосон заалтуудыг зөрчсөний шийтгэлийг зөвхөн өчүүхэн төдий мөнгөөр үнэлж тооцсон нь үнэн хэрэгтээ зөрчих эрхийг худалдсантай утга адил ажээ.

Ийм нөхцөлд төр олигархийн мэдэлд очиж, төрийн үйлчилгээ нь олигархийн дарангуйлал болж хувирахаас өөр зам байхгүй.

7. Үндсэн хууль болон төрийн тогтолцоо бүрдүүлэхэд нөлөөтэй бусад хуулиудад улс төрийн намуудыг аль ч ардчиллын соёлтой улс оронд байхгүй өндөр түвшинд өргөмжилж, зарим тохиолдолд төрийн тэргүүнээс давсан эрх олгожээ.

Түүнчлэн улс төрийн намуудыг төрийн эрх баригчидтай харьцах түвшнээр нь хүртэл ангилж, зарим нам төсвийн хөрөнгөөр санхүүжих боломж олгож байгаа нь нийгмийн амьдралыг бүхэлд нь түүний дотроос, төрийн үйл ажиллагааг улс төрийн хийрхэл, тэмцлийн золиос болгож байна.

Зарим тохиолдолд намын санхүүжилт албан тушаалын гэмт хэрэгтэй сүлбэлдэж байгаа нь төрийн эрхийн төлөө тэмцэл ч ийм шинжтэй болсныг харуулах билээ.

Намууд сонгуульд оролцох эрхийг хандиваар хэмжиж хязгаарлаж Үндсэн хуулийг зөрчиж байхад ч, улс төрийн албан тушаалыг хандиваар үнэлж худалдаж байхад ч, УИХ-ын гишүүн нь чуулган дээрээ төрийн сайд, дэд сайдын суудлын үнэ ханшийг зарлаж байхад ч түүний эсрэг үйлчилж, таслан зогсоох хууль, төрийн механизмгүй байгаа нь ардчилсан нийгэмд намд толгойгоо атгуулсан төр ялзардагийн нотолгоо юм.

8. Бүх шатны төрийн албаны жинхэнэ албан хаагчдын идэвх зүтгэл, ёс суртахуун, ёс зүй нь төрийн дээд албаны хүмүүсийн чанарын шууд тусгал байдаг. Одоогийн төрийн тогтолцоонд төрийн хүний чанарын доройтлын үлгэр дууриалыг УИХ, ЗГ-ын гишүүд үзүүлж, тэр нь доод шатандаа их, бага янз бүрийн тусгал олж хуулбарлагдаж байгааг хэн ч үгүйсгэхгүй.

Ийм байдлын нэг гол үндэс нь УИХ-ын гишүүд, сайдуудын хэрээс хэтэрсэн дархлаа юм.

УИХ-ын гишүүд нь төрийн хуулийг дээдлэн сахихаа илэрхийлж тангараг өргөдөг боловч, эрүүгийн гэмт хэрэг хийхээс бусад ямарч тохиолдолд гэм зэмгүй ажээ. Гэмт хэрэг хийж, мөрдөн байцаалтанд орсон ч түүний УИХ-ын гишүүний эрхийг түдгэлзүүлэхийн тулд Үндсэн хуулийн Цэцийн дарга, Улсын

Ерөнхий Прокурор, Ерөнхий шүүгч нар БХ, нэгдсэн чуулганд танилцуулга хийхээр УИХ-ын тухай хуульд оруулжээ. Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад ч ийм дархлаа байхгүй. Ийм болохоор УИХ-ын гишүүд нийгмийн нүдэн дээр үлгэргүй байдал үзүүлж, хөрөнгө чинээгээрээ гайхуулж, баяр наадам, зугаа цэнгэл эргүүлэх нь эрх мэдэлтнүүдийг бэл хишгээр нь сонгодог одоогийн нийгэмд өөрийгөө харуулах зар сурталчилгаа болдог байна. УИХ, ЗГ-ын гишүүдийн дахин сонгогдож тодрохын баталгаа нь төрийн ажлыг хэрхэн гүйцэтгэсэнээр бус, төсвийн хөрөнгө, төслийн мөнгийг тойрогтоо лоббидоход оршдогийн учир тэд сонгуульт үүрэгтээ хайнга хандаж, харин ч хувийн бизнесээ төрийн мөнгөөр тэтгэхийг хичээх нь цөөнгүй.

IV. ТӨРИЙН ТОГТОЛЦООГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

Нийгмийн амьдралд тулгараад байгаа дээрх асуудлууд цаг үеийн тохиолдлын хүчин зүйлсээс илүү одоо үйлчилж буй хууль, эрх зүйн орчноос төрсөн төрийн тогтолцооны төрөлхийн чанартай холбоотойг судалгаа харуулж байна. Ийм учраас Үндсэн хуулиас эхлэн төрийн тогтолцооны эрх зүйн орчныг бүрдүүлж буй хуулиудыг цогцоор хянаж сайжруулах нь нийгмийг хямралт байдлаас гаргах гол арга зам мөн гэж үзэж дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

4.1. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухайд:

1. УИХ-ыг хоёр танхимтай зохион байгуулж, Доод танхимд хэлэлцэж олонхийн саналаар дэмжсэн хуулийн төслийг Дээд танхимаас олонхийн саналаар дэмжсэн нөхцөлд хүчин төгөлдөр болох зарчмыг хэрэгжүүлэх нь хуулийн чанарыг дээшлүүлнэ.

Тэгэхдээ Дээд танхимын буцаасан төслийг Доод танхим дахин хэлэлцэж нийт гишүүний 2/ 3-оос доошгүй саналаар дэмжвэл хуулийг хоёр танхимын хамтарсан хурлаар хэлэлцэн шийдвэрлэх нь зохистой.

УИХ-ын хоёр танхимын сонгуулийг 2 жилээр зөрүүлж явуулахаас гадна, хоёр жил тутам гишүүдийн 50%-ийг ротацийн журмаар

сонгуульд оруулах нь төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангана.

2. УИХ-ын Доод танхим нь бүрэн эрхийн хугацаанд (4 жил) Засгийн газрыг нэгээс олон удаа огцруулахад хүрвэл өөрөө тарах бөгөөд түүнээс бусад шалтгаанаар тарах асуудлыг МУ-ын Ерөнхийлөгч Дээд танхимд санал үндэслэл оруулж, хэлэлцүүлэн олонхийн саналаар шийдвэрлэх нь хариуцлагыг дээшлүүлнэ.

3. УИХ-ын Дээд танхим нь Доод танхимаас оруулсан хуулийн төслөөс гадна, Доод танхимыг тараах, Улсын Ерөнхий Прокурор, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох, огцруулах асуудлыг МУ-ын Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн шийдвэрлэх;

- Түүнчлэн сонгуулийн хуулийг өөрчлөх, Доод танхимын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эргүүлэн татах асуудлыг нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэх;

- УИХ-ын Дээд танхимыг тараах асуудлыг МУ-ын Ерөнхийлөгчийн санал үндэслэлийг Үндсэн хуулийн цэц хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэх нь шударга ёсыг бэхжүүлнэ.

- УИХ-ын Доод танхим нэг бүрэн эрхийн хугацаанд Үндсэн хуулийг 3 удаа зөрчсөн нь Цэцийн шийдвэрээр нотлогдвол өөрөө тарах шийдвэр гаргана.

4. Төрийн жинхэнэ албан хаагчдын баталгаа, тэднийг бэлтгэх, шалгаруулах, хөгжүүлэх нэгдмэл тогтолцоо болон төрийн албадын үйл ажиллагааны хууль мөрдөх, санхүү эрхлэлтийн хяналтын тогтолцоог Үндсэн хуулийн институт болгож, МУ-ын Ерөнхийлөгчийн ерөнхий удирдлагаар ажиллаж, УИХ-ын Дээд танхимд ажлаа хариуцдаг зарчим хэрэгжүүлэх нь төрийн тогтолцоог улс үндэстнийхээ орчин нөхцөл, төрт ёсны уламжлалд нийцүүлэн төгөлдөржүүлэхэд нэн чухал алхам болно. Эдгээр засаглалын удирдах бүрэлдэхүүнийг МУ-ын Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн 6 жилийн хугацаагаар томилж, ажлыг жил тутам дүгнэж, шаардлагатай тохиолдолд эргүүлэн татаж болох юм.

5. Засгийн газрыг байгуулахад намуудын оролцооны тухай заалтыг Үндсэн хуулиас хасч, МУ-ын Ерөнхийлөгч УИХ-д Ерөнхий сайдын нэр дэвшүүлэхдээ улс үндэсний эрх ашгийн талаас баримтлах зарчмыг заах бөгөөд УИХ-ын доод танхим анхны нэр дэвшигчийг гуравны хоёрын саналаар дэмжихгүй буюу Дээд танхим Доод танхимаас өөрөөр шийдэх бол Ерөнхийлөгч дахин өөр хүний нэр дэвшүүлж, түүнийг Дээд, Доод танхим хамтран хэлэлцэж, олонхийн саналаар дэмжвэл томилж, эс дэмжвэл Доод танхим тардаг байх нь төрийн тогтвортой байдлыг баталгаажуулна.

6. Аймаг, хот, нийслэлийн засаг дарга нарыг томилоход МУ-ын Ерөнхий сайд сонгуулийн дүн болон улс орны нийтлэг эрх ашиг, тухайн

нутаг орны хөгжлийн зорилтыг харгалзан ИТХ-д Засаг даргын нэр дэвшүүлж, тухайн ИТХ олонхийн саналаар хүлээн аваагүй тохиолдолд дараагийн хүнийг нэр дэвшүүлж ИТХ-аар дэмжлэг авахгүй бол ИТХ нь тарж дахин сонгууль явуулахаар Үндсэн хуульд нэмэлт оруулах нь орон нутгийн удирдлагыг бэхжүүлэхэд нааштай нөлөөлнө. Сум, дүүргийн засаг дарга нарыг аймаг, хот, нийслэлийн засаг дарга нь нэр дэвшүүлэн дээрхийн нэгэн адил зарчмаар шийдвэрлэх боломжтой. Харин баг, хороодын дарга нар нь төсвийн захиран зарцуулагч биш тул дээд шатны нь засаг дарга шууд томилох нь зохистой.

7. УИХ-ын хоёр танхимын дарга нарыг тухайн танхимын гишүүд 2 жилийн хугацаагаар олонхийн саналаар сонгож, нэг хүн зөвхөн нэг удаагийн улиран сонгогдох боломжтой байхаар тогтоох нь УИХ-ыг чадваржуулахад нааштай нөлөөлнө.

8. УИХ-ыг сонгох журмыг өөрчлөн Доод танхимын гишүүдийг пропорционал зарчмаар, Дээд танхимын гишүүдийг можаритар зарчмаар сонгохоор Үндсэн хуульд заах нь УИХ-ын гишүүдийн хариуцлагыг дээшлүүлж, сонгуулийг эрүүл шударга явуулахад эерэг нөлөөлнө.

9. Үндсэн хуульд төрийн санхүүгийн засаглалын бүлэг нэмж, төрийн төсөв бүрдэх үндсэн зарчмууд хийгээд жилийн төсөв батлагдсанаас хойш УИХ-ын гишүүд төсвийн зардал нэмэх, улсын нөөц баялгийг хомстгох алив хууль, тогтоол, санаачлахыг хориглон,

төсвийн сахилгыг бэхжүүлэн хариуцлагыг чангатгах заалт оруулах нь авилга, зөрчлийг таслах нэг үндэс болно.

10. Үндсэн хуульд УИХ, Засгийн газрын харилцааны зохицуулалтыг нэмж, Засгийн газар хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн хууль, хуулийн заалтыг УИХ батлахгүй байх нь хуулийн хэрэгжилтийг сайжруулна.

11. Алив хуулийг УИХ-ын хоёр танхимаар хэлэлцэж олонхийн саналаар баталсаны дараа Дээд танхимын дарга гарын үсэг зурж батламжлахын өмнө Үндсэн хуулийн Цэцэд албан ёсоор хүргүүлэн, Үндсэн хууль зөрчөөгүй тухай дүгнэлт Цэцээс авсны дараа, зөвхөн тэр нөхцөлд батламжлах заалт Үндсэн хуульд нэмбэл Үндсэн хуулийн зөрчил, хоригтой холбоотой асуудал шийдэгдэнэ. Үндсэн хуулийн Цэц элдэв эрэмбийн хурал хийхгүй, зөвхөн нэг шийдвэр гаргаж, тэр нь хэн ч үл маргах эцсийн шийдвэр байхаар Үндсэн хуульд заах нь Цэцийн нэгдмэл байдал, хариуцлагыг дээшлүүлнэ.

12. УИХ-ын аль ч танхим хэлэлцэж буй хуулийн төсөл нь Үндсэн хуульд харшилж байгааг Цэцээс анхааруулсаар байтал олонхийн саналаар батлах буюу УИХ-ын шийдвэр Үндсэн хууль зөрчсөнийг Цэц тогтоож шийдвэр гаргавал УИХ-ын гишүүдийн олонхи тангаргаас няцсан хэрэг болох тул МУ-ын Ерөнхийлөгч УИХ-ыг шууд тараах нь төрийг шударга, хууль дээдэлж байх зарчимд нийцнэ.

13. Үндсэн хуульд өөрчлөлт нэмэлт оруулах асуудлыг УИХ олонхийн саналаар зөвшөөрсний дараа заавал бүх нийтийн санал асуулгаар эцэслэн шийдвэрлэж байх; Санал асуулгын үйл ажиллагааг Үндсэн хуулийн Цэц хянаж, дүнг баталсаны дараа Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг Ерөнхийлөгч батламжилна.

4.2. УИХ-ын тухай хуулийг УИХ-ын хоёр танхимтай зохион байгуулалтын шинэ зарчимд тулгуурлан шинэчлэхийн хамт өнгөрсөн 15 жилийн сургамж, туршлагад үндэслэн УИХ-ын үйл ажиллагаа, гишүүдийн бүрэн эрхийн асуудалд дараахь өөрчлөлт хийх шаардлага гарч байна. Үүнд:

1. УИХ-д суудал авсан намууд сонгуулийн дүнгээр 8 суудал авч, бүлэг байгуулан нэгдсэн чуулганд байр сууриа илэрхийлнэ гэж явцуурахгүйгээр цөөнхийн санал, дүгнэлтийг нэгдмэл байдлаар, эсвэл нэгтгэсэн байдлаар сонсож, УИХ-ын гишүүдийн тэгш эрхийг хангах нь Үндсэн хууль, УИХ-ын сонгуулийн утга агуулгад нийцнэ.

2. УИХ нь Засгийн газраас оруулсан хуулийн төслийг хэрэгсэхгүйгээр өөрөө шинэ төсөл “нухдаг”-аа орхих ёстой. Харин Засгийн газрын хариуцлагыг дээшлүүлж, салбарынхаа асуудлаар шаардлага хангахгүй хуулийн төсөл оруулсан сайдыг эгүүлэн татах зарчим баримталбал илүү зохистой.

3. МУ-ын Ерөнхийлөгч УИХ-ын нэгдсэн чуулганд оролцон үг хэлж, санал дэвшүүлэх нь төрийн тэргүүн төрийн хууль тогтоох засаглалд хандсан байр суурь болох тул түүнийг чуулганы албан баримт бичиг болгон гишүүдэд тарааж, УИХ-ын гишүүдийн олонхи нь өөр байр суурь илэрхийлээгүй тохиолдолд УИХ анхааралдаа авсан тогтоол гаргаж байх нь төрийн хариуцлагыг дээшлүүлнэ.

4. УИХ-ын гишүүдийн үндэслэлгүй хаалт баталгаа болж байгаа дархлааг зөөлрүүлж, чуулганы байр, ажлын өрөө, гэр орон, ажилд ирэх, ажлаас буцах замд баривчлах, нэгжих, саатуулахыг хориглож, зугаа цэнгэл, баяр наадам эргүүлэх, хууль бус ан гөрөө хийх, хувийн ажлаар явах үед бусад иргэдийн нэг адил хандах нь зүйд нийцнэ. Түүнчлэн нийгмийн хэв журам зөрчиж, танхайрсан, бусдын амгалан тайван байдал алдагдуулсан, УИХ-ын гишүүдийг элдэв зөвшөөрөл, хамгаалалт гэхгүйгээр захиргааны журмаар түр хорих, эрүүлжүүлэхийг нийтийн жишгээр шийдэх нь төрийг эрүүлжүүлж, нийгэмд эерэг нөлөөлнө. Тэгэхдээ УИХ-ын гишүүнийг гэмт хэрэгт холбогдуулан шүүх, яллах үйл ажиллагааг МУ-ын Дээд шүүх гүйцэтгэх нь “ард түмний элч”-ийн зэрэг дэвд нийцэж, сонгогчдыг хүндэтгэсэн хэрэг болно.

5. УИХ-ын сонгуулийн тойргийн сонгогчдын 10%-иас доошгүй нь тухайн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүн тангаргаасаа зөрж няцаж, сонгуулийн

хөтөлбөр, амлалтаа биелүүлж чадахгүй, тэднийг хууран мэхэлж байгаа буюу өөр шалтгаанаар тэдний “элч” байх чадваргүй гэж үзэж байгаа тухайгаа үндэслэн тайлбарлаж, эргүүлэн татах хүсэл тавьж гарын үсэг зурвал УИХ-ын тухайн танхим ил тод хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэж байх нь сонгогчид төлөөллөөрөө дамжуулан төр барих зарчмыг хэрэгжүүлнэ.

6. УИХ-ын гишүүн сонгуулийн явцад сонгуулийн хууль зөрчсөн, хээл хахууль авилгын мөнгөөр сонгуулиа санхүүжүүлсэн нь тогтоогдвол түүнийг шууд эргүүлэн татах журам тогтоовол хууль биелж, сонгууль шударга болно.

7. УИХ-ын гишүүдийг тойрог хэсүүлэн дахин нэр дэвшүүлэхийг хориглож, дараагийн сонгуульд нэр дэвших бол өмнөх тойрогтоо өрсөлддөг байх нь сонгуулийг шударга явуулах, төр болон улс төрийн хүчний хариуцлагыг дээшлүүлэх, сонгогчид болон УИХ-ын холбоог бэхжүүлэхэд тусална.

8. УИХ-ын гишүүд алив хэлбэрээр улсын төсвийн хөрөнгө мөнгө зарцуулах, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө хуваарилж түгээх, тойрогтоо амлалтаа биелүүлэх нэрээр өөрийн болон бусдын хувийн өмчийн бизнес үйл ажиллагаанд давуу байдал эзэлж, хэвийн бизнесээ сурталчлахыг хориглох нь төр-бизнесийн сүлбээ үүсэхээс сэргийлэхэд ач тустай болно.

4.3. Засгийн газрын тухай хуулийг утга агуулгаар нь шинэчлэн сайжруулах явдал төрийн

тогтолцоог төгөлдөржүүлэхийн нэн чухал үндэс болж байна. Үүний тмлд:

1. Засгийн газрын бүтцийг аль нэг улс төрийн хүч, аль нэг Ерөнхий сайдын сонирхолд нийцүүлэн өөрчилдөг зуршлыг таслан зогсоож, тогтвортойгоор хуульчлан нэг мөр шийдэх нь төрийн хариуцлагыг дээшлүүлнэ.

2. Засгийн газрын гишүүдийг томилохдоо Ерөнхий сайд нэр дэвшигчдийн төрийн ажлын мэдлэг, туршлага, ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг нарийн судалж, ҮАБЗ-өөр хэлэлцэж гаргасан зөвлөмжийг үндэслэн Ерөнхийлөгчтэй зөвлөлдөж байх нь үндэсний эрх ашиг, төрийн чадварыг дээшлүүлнэ.

3. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн хариуцах ажил үүргийн үндсэн хүрээг Засгийн газрын өндөр хариуцлага, төрийн бодлогын гол шугам тогтвортой байх, төрийн хууль хэлбэрэлтгүй хэрэгжих шаардлагад нийцүүлэн шинээр боловсруулж, юуны өмнө, дараах асуудлыг шийдэх шаардлагатай байна. Үүнд:

1) Ерөнхий сайдын хариуцах ажлын хүрээнд эн тэргүүнд:

- Монголчуудын амьдралын түвшин
- Үндэсний хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт
- Улс орны эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн явц, үл давах хүчин зүйлсийн улмаас үүссэн хямрал, бэрхшээлийг давах бэлтгэл, зохион байгуулалт

- Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн үндсэн зорилтуудын биелэлт
- Төрийн захиргааны байгууллагуудын нэгдмэл үйл ажиллагаа, тэдгээрийн дотоод зохион байгуулалт хамаарах

2) Шадар сайдын хариуцах ажлын хүрээнд эн тэргүүнд:

- Засгийн газрын шийдвэрийн биелэлт
- Танхимын гишүүдийн ажлын уялдаа холбоо
- УИХ-тай харьцах асуудал
- Аймаг, хот, нийслэлийн засаг дарга нарын ажлын нэгдмэл удирдлага, үнэлгээ
- Төрийн захиргааны байгууллагуудын жинхэнэ албан хаагчдын чадавхийг хөгжүүлэх бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт хамаарна.

3) Салбарын сайдууд тухайн салбарын асуудлыг цогц хариуцаж, яамдын ажлын зохион байгуулалт, хүний нөөцийн хөгжлийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэх ёстой.

4) Салбарын дэд сайдууд, юуны өмнө, яамны үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж тухайн салбарт, хууль, ЗГ-ын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах үүрэгтэй байх нөхцөлд тэдний орон тоо утга учиртай байх болно.

5) Засгийн газрын алив шийдвэр нь түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл, төлөвлөгөө, үр дүнг үнэлэх дүгнэх журмын хамт батлагдаж хүчин төгөлдөр болдог байх зарчмыг хуульчлан тогтоох нь төрийн үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлнэ.

6) Төрийн захиргааны байгууллагуудын бүтцийг тохируулагч, хэрэгжүүлэх гэсэн “угсраа холбоо”-гоор зохион байгуулж байгаа тогтолцоог халж, салбарын цогц удирдлагын зарчимд шилжих нь шат дамжлагыг цөөрүүлж, хариуцлагыг дээшлүүлнэ. Энэ нь Засгийн газрын бүтцэд ч хамаарна.

7) Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүд хууль зөрчсөн тухай асуудал эрүүгийн гэмт хэргийн шинжтэй биш бол Дээд шүүх хянаж, шийдвэрлэнэ. Хууль зөрчсөн нь Дээд шүүхээр тогтоогдсон ЗГ-ын гишүүн огцорно.

4.6. Ерөнхийлөгчийн тухай хуульд үндсэн хуулийн шинэ нэмэлт, өөрчлөлтийн дагуу өөрчлөлт оруулахын хамт Ерөнхийлөгчийн үндсэн, бүрэн эрхийн хүрээнд дараахь асуудлыг нэмж оруулах нь улс орны хөгжил дэвшил, төрийн чадавхийг дээшлүүлэхэд ач холбогдолтой болно гэж үзэж байна. Үүнд:

- МУ-ын үндэсний хөгжлийн хөтөлбөрийн удирдагч байж, түүнийг үндэсний зөвшилд хүргэн УИХ-д хэлэлцүүлэн батламжилж, түүнийг хэрэгжүүлэхэд засаглалын бүх салбарын үйл ажиллагааг уялдуулан чиглүүлнэ.

- Төрийн албаны бүх салбарт боловсон хүчний нөөц бүрдүүлэх, хөгжүүлэх, тэдний ажил, амьдралын баталгааг сайжруулах төрийн нэгдмэл бодлогыг тодорхойлж, түүний хэрэгжилтийг ерөнхий удирдлагаар хангана.

- МУ-ын Ерөнхийлөгч жил тутам өөрийн үйл ажиллагааны үр дүн, улс орныхоо нөхцөл байдалд өгч байгаа үнэлэлт, дүгнэлтээ ард

түмэндээ хандсан илгээлтээр илэрхийлдэг байх нь бүх нийтээр сонгогдсон төрийн тэргүүний заавал хэрэгжүүлэх үүрэг мөн болно.

4.5. Сонгуулийн хуулийн Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн дагуу шинэчлэхээс гадна, дараахь асуудлыг тодорхой шийдэхийг өнгөрсөн хугацааны үйл явдлууд шаардаж байна. Үүнд:

1. Сонгуулийн ерөнхий хороог УИХ-аас баталж байгааг өөрчлөн, Сонгуулийн ерөнхий хороо нь Үндсэн хуулийн Цэцэд харъяалагдаж, Цэцээс томилогдож ажлаа түүнд хариуцах бөгөөд сүүлийн 3 жил аль нэг намд харъяалагдаагүй хүмүүсээс бүрдэж, СЕХ-ны дарга, нарийн бичгийн даргыг гишүүдийн нууц санал хураалтаар сонгох нь сонгуулийг улс төрийн дарамтаас чөлөөлөх үндсэн нөхцөл болно.

2. Сонгуулийн тойргийн хороодыг СЕХ-оос, салбар, хэсгийн хороог тойргийн хорооноос дээрх зарчмаар байгуулж болно.

3. УИХ-ын сонгуулийн дүнг Үндсэн хуулийн Цэц хэлэлцэн баталсны дараа сонгууль хүчин төгөлдөр болно.

4. Одоогийн сонгуулийн хуульд элдэв зөрчлийг “хориглоно” хэмээн тунхаглаж, “хориг”-ийг торгуулиар арилжсан зарчмыг халж, нэр дэвшигч, түүний төлөөлөгч, түүнийг нэр дэвшүүлсэн нам сонгуулийн хууль зөрчсөн нь тогтоогдсон нэр дэвшигчийг СЕХ-д мэдэгдэн сонгуулиас шууд хасч, хэрэв сонгуулийн хорооноос ямар ч хэлбэрээр хууль

зөрчсөн нь баримттай тогтоогдвол сонгуулийг хүчингүй болгож, сонгуулийн зардлыг төлүүлэх нь сонгуулийг шударга явуулах үндсэн нөхцөл болно.

5. Сонгуульд зөвхөн улс төрийн намууд өрсөлдөх давуу нөхцөлийг халж, сонгуулийн тойргийн сонгогчдын 10%-иас доошгүй нь нэр дэвшүүлэх, 3 жилээс доошгүй хугацаанд тухайн тойрогт хууль, дүрмийн дагуу нийтлэг үйл ажиллагаа явуулсан иргэний нийгмийн байгууллагын эвсэл, холбоод сонгогчдын 10%-иас доошгүйн дэмжлэг олбол сонгуульд оролцох боломж бүрдүүлэх нь ардчиллыг хөгжүүлж, намуудыг эрүүл төлөвшүүлэх, сонгуульд бүх нийтийг хамруулахад тус дөхөм болно.

4.6. Улс төрийн намын тухай хууль төрийг эрүүлжүүлэх, намуудыг хууль дээдлэх зарчмаар төлөвшүүлэх одоогийн хурц шаардлагад нийцүүлэн шинэчлэхэд дараах чиглэлүүд шийдвэрлэх ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

4.6.1. Сонгуульд оролцох явцдаа сонгуулийн хууль зөрчсөн буюу санхүүжилтийн журам зөрчсөн, хээл хахууль, авилгын мөнгөөр санхүүжсэн, гишүүд нь сонгуульд оролцоход мөнгө хөрөнгө хандивын болзол тавьсан намыг тухайн зөрчил илэрсэний дараахь бүх шатны сонгуульд оролцох эрхийг Дээд шүүхийн шийдвэрээр халах;

4.6.2. Намын санхүүжилтэд эд хөрөнгийн түрээсийн орлогыг оруулах нь далд эдийн засгийн нэг хэлбэрийг өөхшүүлэх бөгөөд эцэстээ

улс төрийн бохир орчин бүрдүүлэх нэг үндэс болох тул хуулиар хориглох нь зүйтэй юм.

4.6.3. Одоогийн улс төрийн намуудын зохион байгуулалтын зарчим нь “Авангард” намын загварыг хуулбарлаж байгаа тул НУЗ нь ЗГ-ыг унагахыг ч, төрийн зохион байгуулалтыг ч өөрчлөх асуудлыг илэрхий эрхэлж, ЗГ-ын гишүүд, УИХ-ын гишүүдэд даалгавар өгч байна. Намын тухай хууль (7-р зүйл)-д хориглосон тунхаг энэ үйлдэлд саад болж чадахгүй байна. Ийм нөхцөлд УИХ, ЗГ-ын гишүүдтэй намаас нь харьцах хэм хэмжээг нормчилж тогтоох зайлшгүй шаардлага гарч байна. Үүний тулд УИХ, ЗГ-т ажиллаж байгаа намын гишүүд төрийн бодлого, бүтэц зохион байгуулалтын талаар баримталж байгаа байр сууриа сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрөөс гажаагүй тохиолдолд намын удирдлага нь өөрчлөх, үүний тулд дарамт шахалт үзүүлэх эрхгүй бөгөөд үүнийг зөрчвөл тухайн нам дараагийн сонгуульд орох эрхийг Дээд шүүхээс хасах шийдвэр гаргах нь зүйд нийцнэ.

4.7. Төрийн албаны тухай хуульд төрийн албаны үйл ажиллагаанд тулгарч байгаа одоогийн бэрхшээлтэй байдлыг гэтэлж, төрийн найдвартай, хариуцлагатай, үр өгөөжтэй ажиллагааг хангахад чиглүүлэн зарчмын өөрчлөлтүүд хийх шаардлага тулгарч байна. Үүнд:

4.7.1. Төрийн жинхэнэ албан хаагчдад зөвхөн гавьяа зүтгэлийн зэрэг дэв олохоос гадна, түүнийг эрхлэх ажил, албан тушаалын

чиглэлээр нь сонгох бэлтгэх, томилох ажлыг эмх цэгцтэй, хяналттай болгохын тулд категориор ангилан, зөвхөн тогтоосон журмаар шат ахих хөдөлгөөнийг журам болгох хэрэгтэй байна.

4.7.2. Төрийн жинхэнэ албан хаагчдыг дээд сургуулийн шатнаас сонгож бэлтгэх, дадлагуулах, хөгжүүлэх, энэ салбарт төрийн бодлого хэрэгжүүлэх тогтолцоог улс төрийн намуудын оролцоо, нөлөөнөөс бүрмөсөн салгаж, цогц зохион байгуулан чиг удирдлагыг МУ-ын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд хамааруулах нь төрийг чадваржуулахын үндэс болно.

4.7.3. Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академийг нэгтгэн нэг албаны хоёр агентлаг болгож, тухайн албыг МУ-ын Ерөнхийлөгчид харъяалуулах нь төрийн тэргүүний ард нийтээр сонгосон статус хийгээд төр аль нэг намаас хараат биш байх нөхцөлийг хангана.

4.7.4. Төрийн албаны зөвлөлийг бүрдүүлж буй одоогийн журмыг өөрчилж, түүнийг төрийн жинхэнэ албан хаагчдын Их хурлаас 11-15 хүнээр бүрдүүлж дарга, дэд даргыг Зөвлөлийн гишүүдээс МУ-ын Ерөнхийлөгчийн оруулсан саналыг хэлэлцэн нууц санал хураалтаар 7 жилийн хугацаагаар сонгох нь уг албаны тогтвортой, стратегийн чиг бодлоготой үйл ажиллагааг хангана.

4.7.5. Төрийн албаны зөвлөлийн ажлын албыг өргөтгөн, түүний чиг үүрэгт зохицсон бүтэцтэй болгохоос гадна, Төр судлалын

эрдэм шинжилгээний байгууллагатай болгож, судалгааны дүнг нийт төрийн жинхэнэ албан хаагчдыг сонгох, бэлтгэх, хөгжүүлэхэд ашиглах нь төрийн албаны ажлын шинжлэх ухааны түвшинг дээшлүүлж, ажиллагсдын хөгжлийг хангах үндсэн нөхцлийг бүрдүүлнэ.

* * *

Монгол Улсын төрийн тогтолцоог хөгжүүлэх дээрх саналууд нь аль нэг улс төрийн хүч, нийгмийн бүлгийн ашиг сонирхол, үзэл баримтлалд хязгаарлагдаагүй бөгөөд ардчиллын зарчим, үнэт зүйлсийг хадгалаж бататгах хүрээнд өөрийн орны төрт ёсны уламжлал, өнгөрсөн 15 жилийн сургамж, туршлагыг үнэлж, ардчиллын өндөр соёлтой, хөгжлийн өндөр түвшинд хүрсэн орнуудын төрийн тогтолцооны зүй тогтол, онол, арга зүйг өөрийн нөхцөл байдалд нутагшуулан хэрэглэхийг зорьж байгаа болно.

Төрийн тогтолцоог хөгжүүлэх талаар дэвшүүлж байгаа эдгээр саналууд нь төрийг нэгдмэл цогц бүрдэл хэмээн үзэж, түүний бүх организм салаа мөчрийг тэнцвэртэй хөгжүүлэх зарчимд тулгуурлаж байгаа тул хоорондоо нягт холбоо шүтэлцээтэй бөгөөд түүнийг иж бүрнээр нь хэрэгжүүлсэн тохиолдолд л үр дүн нь гүйцэд илэрнэ.

*МУ-ын Ерөнхий сайд асан,
МУ-ын гавъяат эдийн засагч
Проф. Д.Бямбасүрэн
2007-04-10*

“МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ОДООГИЙН БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ГОЛ ЧИГЛЭЛҮҮД” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор Д.Бямбасүрэнгийн “Монгол Улсын төрийн тогтолцооны одоогийн байдал, түүнийг хөгжүүлэх гол чиглэлүүд” лекц 2007 оны зургаадугаар сарын 12-нд ННФ-ын хурлын танхимд боллоо. Лекцийн эхэнд ННФ-ын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал үг хэлж, лекцийн дараа оролцогчид санал хүсэлтээ хэлж, илтгэгчид хандан асуулт тавилаа.

Жудаг /Иргэн/

Би 1992 оны сонгуульд дүн шинжилгээ хийж “Үнэн замаар явбал үхэр тэргээр туулай гүйцнэ” гэсэн ном гаргасан. Мөн “Зайлшгүй тулгамдсан засаглалын хувьсгалыг би ингэж хийнэ, харин таны санал ямар байна”, “Монголын үнэртэй улстөрийн тогтолцоо

ба миний 45 жилийн тэмцэл” гэсэн ном гаргасан. Би бүрэн бүрэлдэхүүнтэй их хурал байгуулья, бага хуралтай больё гэсэн саналтай байдаг. Энэ юу вэ гэвэл хөдөөгийн сум бүрээс нэг, хамгийн олон хүнтэй таван аймгийн төвөөс гурав, хамгийн цөөн хүнтэй таван аймгийн төвөөс нэг, Улаанбаатар хотоос 20 хүнтэй бөгөөд нийт 372 гишүүнтэй Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг байгуулья гэсэн санаа юм. Яагаад гэвэл Монголд иргэний нийгэм байгуулах гэж байгаа. Энд намуудыг оролцуулахгүй. Яг 1990 оных шиг иргэдээс нэр дэвшигчдээ сонгодог нь зүйтэй байх гэж үзсэн. Харин хоёрдахь шатны сонгууль явуулна. Тэр сонгууль нь 372 гишүүний хүрээнд явагдана. Харин энэ дээр намууд нэр дэвшүүлнэ. Гэхдээ тодорхой хязгаартай. Ямар хязгаартай байх вэ гэдгийг Их хурал хуралдаж тогтооно. Жишээ



нь, Улсын бага хурал таван байнгын хороотой, нийтдээ таван тавын 25 гээд дээр нь нэг даргаа нэмээд үзэхээр 26 гишүүний бүрэлдэхүүнтэй хууль тогтоогч байгаа юм. Засгийн газар таван яамтай, нэг шадар сайдтай, ерөнхийлөгч нь Засгийн газраа удирдана. Тэгэхээр 26 дээрээ 7-гоо нэмэхэд 33 хүн болчихно. Түүн дээр ерөнхий шүүгч нэмэгдээд Монгол улсыг 34 хүн л удирдаж, хяналт тавьж байх юм. Энэ нь зүйтэй болов уу гэж бодож байна. Нам бүрээс 34 хүртэл хүний нэрийг дэвшүүлэх эрхтэй. Мөн түүний дээр Их хурлын гишүүдээс ганц хоёр хүний нэр дэвшүүлэх эрх байх нь зүйтэй гэж бодож байгаа. Жишээ нь, МАХН академич Нарангэрэлийг хэзээ ч дэвшүүлэхгүй, академич Амарсанаа аль ч намын харьяалалгүй, тийм учраас Их хурлын гишүүд ийм хүмүүсийг дэвшүүлэх боломжтой.

Түүний дараа сонгуулийн хуудсан дээр хэн хэний нэрийг бичих вэ гэсэн том асуудал бий. Энд зургаан шат байх хэрэгтэй. Хамгийн эхэнд нэр дэвшсэн хүмүүс таван минутийн хугацаанд өөрийгөө танилцуулна. Үүнийг телевизийн бичлэг хийнэ. Дараа нь Их хурлын гишүүдийн саналаар зарим хүнийг Их хурал дээр ирж танилцах ажил хийх нь зүйтэй. Түүний дараа бүх нэр дэвшигчээс 25-аас хэтрэхгүй хувийг нь сонгуулийн хуудсанд бичүүлэхээр гишүүн бүр санал тавина. Энэ жагсаалтыг үндэслээд хамгийн олон санал авсан хүнээс нь эхлэн дугаарлаж 33.3 хувийг нь сонгуулийн хуудсанд бичнэ. Их хурлын гишүүн бүр 34 хүнээ л

сонгоно. Хамгийн сайн гэсэн 34 хүндээ оноо өгнө. 33, 34-р хүн гээд явахад 34 нь нэг оноотой байна. Оноогоор тоолж үзэхэд байр эзэлсэн дараалал гарна. Хамгийн өндөр оноо авсан хүн, жишээ нь, Ерөнхий сайд болно гэсэн үг. Тэр ганцаараа төрийн хамгаалалтад байна. Монгол шиг жижигхэн, ядуу оронд тийм олон хүнийг төрийн хамгаалалтад байлгах хэрэггүй гэж үзэж байгаа. Иймэрхүү байдлаар албан тушаалыг амлаж авбал хахууль энэ тэр байхгүй болох юм гэж үзэж байна.

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/
Бага хурлын гишүүдийн чихийг “мушгина” энэ тэр гээд ирвэл юу болдгийг та бүхэн мэдэж байгаа. 1992 онд Засгийн газрыг огцруулна гээд 70 хэдэн хувь нь жагсаал энэ тэр хийж орж ирээд, энэ муу Засгийн газрыг огцруулж чадаагүй юм чинь гээд бүтэн жил хэрүүл хийгээд. Сүүлдээ тиймэрхүү юм руу орно. Бид байнгын мэдээлэлтэй, хариуцлагатай институцийн тухай л яриад байна л даа. Тийм учраас минийх бол арай өөр юм.

Долгион /”ММ” агентлагийн сурвалжлагч/
Үндсэн хуульд өөрчлөлт оруулна гэж таны илтгэлд бичжээ. Үндсэн хууль амьтай организм биш. Тухайн үед нийгмийн нөхцөл ямар байсан, ирээдүйд ямар нийгмийг цогцлоон байгуулах гэж байгаа гэдэг дээр үндэслэж 1992 онд анх Үндсэн хуулиа баталсан юм биш үү. Түүнээс хойш 15 жил өнгөрөөд

байна. Энэ хугацаанд Үндсэн хуулийг өөрчилж байсан. Одоо өөрчлөх талаар яригдаж байна. Таны хэлсний дагуу өөрчиллөө гэж бодоход дахиад 15 жилийн дараа, мөн дахиад 15 жилийн дараа Үндсэн хуулийг өөрчлөх процесс зогсолтгүй үргэлжлээд байх юм биш үү?

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Ер нь нийгмийн байгуулал огцом өөрчлөгдөж байгаа нөхцөлд нийгмийн амьдралд яв цав тохирсон Үндсэн хууль төрнө гэж хүлээх хэрэггүй. 1992 онд их том алхам хийсэн. Хүний эрхийн асуудлыг үндсэнд нь баталгаажуулж эдийн засгийн олон асуудлыг Үндсэн хуулиар шийдсэн.

Харин сүүлд нь Үндсэн хуульд 20 минутийн дотор өөрчлөлт оруулсан. Түүгээр ард түмний сонгосон төрийн тэргүүний толгой дээр намын “сэлэм” аваачаад тавьчихсан. Үүнээс болж өнөөдөр ямар байдалд хүрээд байгаа билээ. Энэ Үндсэн хуулийг өөрчлөхгүйгээр бид явахгүй ээ.

Ганцхан танхимтай парламент байгаа нь өнөөдөр хачин хачин хууль гаргахад хүргээд байгаа. Казиногийн нэг хууль гаргана, дараа нь хүчингүй болгочихно. Дараа нь бас нэг өөр Казиногийн тухай хууль орж ирж байх жишээтэй. Бүр хачин хууль гээч. Ашигт малтмалын болон Татварын тухай хуулийг та бүхэн хар л даа. Татвар буурсан гэж яриад байна. Ерөнхий дүнгээрээ бол буурсан байх. Гэхдээ л талх иддэг хүмүүс зургаан

хэрчим талхныхаа нэгийг нь татварт төлсөөр л байгаа шүү дээ. Зөвхөн мөнгө төгрөг олдог олигархиудын чинь татвар л буурсан байгаа. Хоёр танхимтай болгоно гэдэг бол ганцхан Монголд хийх гэж байгаа зүйл биш. Ардчиллын соёлтой бүх оронд байдаг л зүйл. Үүнээс тойрч гарах арга байхгүй.

Нөгөө талаас УИХ-ын гишүүдийн баталгаа гээд Үндсэн хуульд дархлаа хийгээд өглөө. Энэ нь юунд хүргэж байгааг өдөр тутамд харж байна. Сүүлдээ телевизор харахаас ч дургүй хүрдэг боллоо. Бид үнэхээр өөрсдийгөө зохицууцах чадвартай, буцах холбоотой тогтолцоонд шилжье гэж бодож байгаа бол Үндсэн хуулиа сайжруулж явах хэрэгтэй. Магадгүй цаашид нэг биш удаа сайжруулж ч болох байх.

Би түрүүн санхүүгийн засаглалын тухай ярьсан. Яагаад Монголын ҮНБ гурав дахин нэмэгдэж байхад ард түмний амьдрал 20 хувь дээшилсэнгүй вэ. Санхүүгийн засаглалын тухай асуудлыг Үндсэн хуульд орхисноос болж УИХ, Засгийн газар дураараа аашлан төсвөө нэмсээр ҮНБ-ий 41.7 хувийг нь төвлөрүүлж 250 саяар нь хуваан алтан загасны үлгэр шиг юм болчихоод сууж байна. 250 саяыг юунд зарцуулж байгааг нь сонин хэвлэлээс харж л байгаа шүү дээ. Багын даргын контор л гэнэ. Жорлонтой контор барьж л таараа. Нүх ухаж л таараа. Эндээс үзэхэд УИХ-ын гишүүн хөдөө очиж төвлөрсөн төсвийн хөрөнгөөр багийн даргын жорлонг ухаж өгөх нь. Энэ замбараагүй

байдлаасаа гаръя, эх орныхоо үндэсний эрх ашгийг бодъё гэвэл Үндсэн хуульд өөрчлөлт хийн сайжруулах хэрэгтэй.

Долгион /”ММ” агентлагийн сурвалжлагч/
Улс төрийн албан тушаалтнууд Үндсэн хуулиа сахихгүй байгаа нь хуулийн буруу биш, тухайн хүмүүсийнх нь буруу юм биш үү?

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/
Үндсэн хуулиар олгогдсон эрх нь тэр юм. Сахихгүй байх эрхийг нь өгчихсөн юм шиг байна.

Янжмаа /”Өдрийн сонин”-ы сурвалжлагч/
УИХ-ын гишүүдийг ротациар сэлбэх тухай асуудал их шинэлэг, сонирхолтой юм шиг надад санагдлаа. Бусад оронд ийм жишиг байдаг уу? Энэ нь УИХ-ын гишүүд болон намуудтай хариуцлага тооцох өвөрмөц хэлбэр гэж бодож байна.

Хууль баталж байгаа УИХ-ын гишүүдийн амнаас “за яахав, хэрвээ Үндсэн хууль зөрчсөн бол Цэцэд очоод эргээд ирнэ биз” гэх маягийн үг гардаг болжээ. Ингэж хууль тогтоох дээд байгууллага нь Үндсэн хууль зөрчсөн шийдвэрүүд гаргаж болж байна уу. Таны илтгэлд хууль батлагдахаас өмнө Цэцэд очоод тэндээс Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж, түүний дараа хуулийг эцсийн байдлаар батлана гэсэн санал гаргасан байна лээ. Миний бодлоор УИХ-аас хууль

батлагдахаас өмнө Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар зөвлөгөө өгдөг мэргэжилтнүүдийн баг байвал Цэцэд хандсанаас илүү байх юм биш үү?

Улс төрийн намуудын нэр дэвшигчдийн 20 сая төгрөгт та нэлээн шүүмжлэлтэй хандаж байна. Миний бодлоор улс төрийн намуудын санхүүг ил гаргаж байгаа нь зарим талдаа зөв юм шиг санагддаг. Хэрвээ та үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол өөр ямар байдлаар үүнийг хийж болох вэ?

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/
Дөрвөн жилд нэг удаа сонгууль явуулахад 77-85 хувь нь солигдож байна гэж би түрүүн хэлсэн. Улс төрийн хүчнүүдийн рейтинг маш хүчтэй савлаж байна. Ийм нөхцөлд нийгмийн амьдрал тогтворжиж чадахгүй. Тийм учраас ротаци бол үйл явцыг ламинар урсгалд оруулахад хэрэгтэй болов уу гэж бодож байгаа.

ҮХЦ-ийн оронд экспертүүд гэж байна. УИХ өөрөө эксперт юм. Тэнд хангалттай туслах, зөвлөх, ажилтнууд бий. Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг зөвхөн Цэц л шийднэ. Эксперт шийдэхгүй. Магадгүй эксперт Үндсэн хууль зөрчиж байна гэснийг Цэц зөрчөөгүй байна гэж үзэж болно. Эцсийн үг Цэцэд байх юм.

Би Францын Үндсэн хуулиас санаа авч хийсэн. Хэрэв дээд танхимаас та нар Үндсэн хууль зөрчих нь байна шүү гэхэд тухайн хууль батлагддаггүй л байх ёстой. Тэгвэл одоогийнх

шиг хачин хямрал үүсэхгүй шүү дээ. Төрийн хямралаас гадна Үндсэн хууль зөрчсөн шийдвэрүүд ямар үр нөлөөтэйг бид харж байгаа шүү. Ашигт малтмалын тухай хууль дээр ямар үр нөлөө байна.

1992 оны сонгууль мөнгөөр явагдаагүй. Яахав, зардал гарсан байх л даа. 1996 оны сонгуулийн дараа гарсан мэдээ баримтуудаас үзвэл нэг суудал ойролцоогоор 3.5 сая төгрөгийн үнэтэй байсан. 2000 онд 30-аад сая болсон байгаа юм. 2004 оны сонгуулиар 50 саяас даваад явсан. Тэгэхээр сонгууль нь, сонгуулийн хууль нь ч ийм байдлыг бий болгож байна. Хөрөнгө мөнгөөр өрсөлдөх уралдаан явж байгаа. Яагаад сарын 120 мянган төгрөгийн цалингаараа амьдардаг, дунд сургуулийн багш хүн, эсвэл, эмч хүн аль нэг намаас нэр дэвшээд УИХ-ын гишүүн болж болдоггүй юм бэ. Яагаад нэр дэвших эрхийнхээ төлөө 20 сая төгрөгийг тухайн намд төлөх ёстой гэж. Нам санхүүгээр ядраад байгаа бол гишүүдээсээ хандив цуглуулж, татвар авна гэвэл өөр асуудал. Тэр ч бүү хэл, одоогийн Намын тухай хуульд өмч хөрөнгөө түрээслүүлнэ гэж заалт байгаа. Энэ ер нь мэдэхгүй дээ. Ямар нэг гэмт хэргийн үүр уурхайг бий болгоход хүргэж ч болно шүү дээ. Тэгэхээр намын санхүүжилтийн асуудал дээр хуулиа чангатгахгүй бол бид буруу тийшээ явчих гээд байгаа нь харагдаж байна. Тийм учраас доод танхимыг пропорционалиар, дээд танхимаа можираториор сонгоё гэж ярьж байгаа юм. Энэ бас боломж шүү дээ. Намын

хариуцлагыг ч дээшлүүлнэ. Гэхдээ ганцхан нам биш. Одоо манайханд ийм ойлголт байх юм. Нам л сонгуульд орох ёстой гэж. Яагаад иргэний хөдөлгөөн сонгуульд орж болохгүй гэж. Иргэний хөдөлгөөн нийгмийн тодорхой нэг хурц асуудалд чиглэсэн зорилт дэвшүүлж байдаг утгаараа харин ч нийгэмд эерэг нөлөөлөх төдийгүй догматик биш байдлаар хандах боломжтой байдаг. Энэ талаас нь бид бас бодолцох л хэрэгтэй байх.

Д.Энхбат /Иргэний холбоо/

Өнөөдөр Монгол улсад шилжилтийн үе дуусахгүй байна. 1990 оноос өмнө улс төрийн цөм нь нам байсан. 17 жилийн дараа эргэн харахад харамсалтай нь Монголын нийгмийн цөм шинэчлэгдэж чадсангүй. Тойроод бүх юм шинэчлэгдээд байдаг. Цөм нь шинэчлэгдэхгүй байсаар одоо бүр ялзарч эхэлсэн. Тухайн үед зэрэгцэж үүссэн АН-д энэ нь халдварлаж, бас ялзарсан.

Герман, Чех зэрэг оронд улс төрийн намуудаа татан буулгасан явдлыг маш зөв хийсэн юм байна гэж би ойлгодог. Бид энэ зовлонг 17 жил сунгаж, 17 жилийн өмнөх Герман, Чехийн асуудалтай дахиад л тулж байна. Ямарваа нэгэн систем оршин тогтнож л байвал дотроо зөв байдаг. Зөрчилгүй гэсэн үг. Өнөөдрийн бүх проблемын буруутан бол улстөрийн намууд юм. Гэтэл энэ алдааг засах хүчин нь манай хуулиар бас л улстөрийн намууд байдаг. Өөрөөр хэлбэл, буцах холбоо үүссэнгүй, битүүрчихлээ. Турк, Тайланд зэрэг

оронд буцах холбоог нь арми гүйцэтгэдэг. Улс төрийн намууд буруу явбал арми ороод ирнэ. Америк, Герман, Франц зэрэг оронд буцах холбоог нь иргэний нийгэм гүйцэтгэдэг. Харамсалтай нь, энэ гурван зам гурвуулаа Монголд явахгүй болчихлоо. Манайд арми байхгүй. Иргэний нийгэм нь сул. Нам нь ялзарчихсан. Гэхдээ Дарвины хуулиар бол аргагүй эрхэнд шинэчлэгдэх байх л даа.

Ойрын хугацаанд Хятад, Орос хоёроос түрүүлээд таны хэлж байгаа өөрчлөлтүүдийг хэн хийж чадах вэ?

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/
Үнэхээр тийм ээ. Манайд өмнө нь авангард хэлбэрийн нам байсан. Сүүлд шинэчлэгдэж үүссэн намууд аяндаа авангард хэлбэрээсээ гулссаар байгаад эрх баригч бүлэглэлийнхээ үзэл бодол гэхээсээ илүү хөрөнгө мөнгө, ашиг сонирхлоор нэгдсэн бүлэглэлүүдийн гарт орж эхэлсэн. Тэр байтугай Монголд нам дамжсан олигархиуд байгаа нь нэгэнт бодит зүйл болсон. Ийм нөхцөлд намуудын хувьд их түвэгтэй. Бид харж л байгаа шүү дээ. Өдөр тутам харж байгаа. Гэхдээ АН-ын хувьд 1990 онд ардчиллын үзэл санааг анх тээж гарсан шинэ улстөрийн хүчин хөдөлгөөн дээр тулгуурладаг утгаараа бас чиг нэлээн боломжтой. Гэхдээ ний нуугүй хэлэхэд ганцхан намд найдах биш, одоо ардчиллын хоёрдугаар эгнээ урагшаагаа гарах цаг болсон. Хоёрдугаар эгнээ бол иргэний нийгэм,

иргэний хөдөлгөөнүүд юм. Энэ л цаг үед тулж ирээд байна. Үүнийг улс төр сонирхдог, боддог хэн ч гэсэн олж харах ёстой. Тийм ч болохоор би намуудын асуудал дээр байр сууриа илэрхийлж байна.

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Манай төрийн тогтолцоог боловсронгуй болгох зайлшгүй шаардлага бий болсон гэдэгтэй санал нэг байна. Энэ нь олон түмний ярьж, хэлж байгаа зүйлээс маш тодорхой. Энэ илтгэлээр төрийн тогтолцоог боловсронгуй болгох ямар арга зам байна гэдэг дээр тодорхой саналуудаа нэгтгэн, аль болох цогц, уялдаатайгаар шийдэх оролдлого хийсэн байна.

Илтгэлд АИХ, УБХ гэсэн хоёр танхимаа тус тусад нь сонгоно гэлээ. Миний бодлоор ингэж хоёр сонгууль явуулах хэрэггүй байх. АИХ-ыг бүх ард түмний саналын үндсэн дээр сонгогчоод түүнээсээ бага хурлаа томилдог байвал зүгээр болов уу.

АИХ-ын гишүүдийн ихэнх нь тухайн сонгогдсон тойрогтоо тогтмол ажилладаг, амьдардаг байвал зүйтэй. Тэр аймгийнх, энэ аймгийнх гэсэн мөртлөө дандаа хотынх, эсвэл, аймгийн хүн энд ирээд танхимд суучихдаг. Үнэн хэрэгтээ ард түмнээсээ тасарчихсан байгаа. Төрийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэсэн Үндсэн хуулийн зарчмын том заалт энд алдагдаад байна. Төр, ард түмэн уялдаатай байх хамгийн гол, сайн механизмын

нэг нь энэ. Энд тогтмол хуралдаад байхгүй. Жилдээ 2-4 удаа хуралдана. Харин бага хурал нь үргэлж хуралдаж хууль журмаа боловсруулдаг байх нь зүйтэй.

Сонгуулийн хуулийг боловсронгуй болгохгүйгээр энэ асуудлыг шийдэж чадахгүй. Болохгүй байгаа хамаг гай нь улс төрийн намуудад байна гэж хүмүүс бухимдаж байгаа шүү дээ. Үнэндээ намдаа ч биш юм. Намыг авч явж байгаа удирдлагын ихэнх нь буруу ажиллаж байгаад хамаг учир байна. Тийм учраас энэ бол маш их оносон асуудал гэж би бодож байгаа. Энэ асуудлыг олон удаа бичиж, намын дарга нартай санал солилцож үзсэн. Ер нь их сонин санал байна гэхичээд цаашаа хараад орхичихдог. Яг ийм байдлаар нэлээн хэдэн жил явж байгаа. Одоогийн намууд төвтэй болсон засаглалын үед үүнийг өөрчлөх асуудлыг намуудаар дамжуулж шийднэ гэвэл болохгүй юм шиг байгаа юм. Гэхдээ ямар механизм байх вэ гэдэг дээр шууд хариулж мэдэхгүй байна. Ямар ч гэсэн Үндсэн хуулийг боловсруулах асуудлыг шийдэх, зохион байгуулах үүрэг хүлээсэн хүмүүс нь намынхаа эрх ашгийг хамгаалж буй нөхцөлд шийдүүлэхэд үнэхээр хэцүү. Тийм учраас төрийн тогтолцоог ямар зохион байгуулалттайгаар боловсронгуй болгох юм бэ гэдгийг цааш нь сайн ярих хэрэгтэй байх. Иргэний хөдөлгөөнүүд дундаас маш сайн санаачилга гарахыг ч үгүйсгэхгүй. Төрийн бүх шатны байгууллагын удирдах албан тушаалд

ямар нэг улстөрийн намын гишүүн байхыг хориглосон хуультай болох хэрэгтэй. Тэгвэл намдаа захирагдаж явахгүй, жинхэнэ улс орныхоо эрх ашгийн төлөө сонгогчдоосоо хүлээсэн үүргийнхээ дагуу өөрийн совестиор ажиллах бололцоотой болно байх.

Илтгэлд УИХ-ыг тараах асуудлыг ҮХЦ шийднэ гэсэн санал явж байна. Энэ ямар байдаг юм бол оо. Арай ч гэж эргэлзмээр санагдаж байна. Цэц санал гаргадаг, түүний дагуу УИХ олонхиороо шийдвэр гаргадаг өөр механизм байх хэрэгтэй юм.

Ерөнхийлөгчид хэтэрхий их эрх мэдэл өгөх, бүр АИХ-ыг тараах хүртэл эрх өгсөн санаа байна. Үүнийг зассан эсэхийг мэдэхгүй байна. Ерөнхийлөгчийн засаглалтай болох тийшээ нэлээн хэлтийсэн санал юм уу гэж ойлгож байгаа. Үүнийг Монголын нийгэм нэг их дэмжихгүй, хүлээж авахгүй байх шүү.

Сая илтгэлээр “нэг хүний дарангуйллаас олонхийн дарангуйлал гарахаараа улам хэцүү” гэсэн санаа гарч ирэх шиг болно лээ. Ямар чиглэлээр дарангуйлал байх вэ гэдгээ бодох хэрэгтэй байх. 200, 300 гаруй АИХ-ын гишүүн гарч ирээд бүгд нийлээд буруу дарангуйлал үүснэ гэдэгт би нэг их зовохгүй байгаа. Үүнийг анхаарах хэрэгтэй. АИХ, УБХ гэсэн хоёр танхимтай парламенттай болчихвол нэг танхимтай парламентын үед гарч байсан зовлон бэрхшээлийг давах гарц байх юм биш үү.

Хариуцлагын тогтолцоог сайжруулах асуудлыг цуг бодолцох нь мэдээж. Засгийн газрын бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлыг нэлээн ярьсан. Би энэ дээр нэг л зүйлийг ярьдаг юм. Одоо манай Засгийн газрын бүрэлдэхүүнд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг цогцоор боловсруулан барих бүтэцгүй байгаа. Дээр үед улсын төлөвлөгөөний комисс гэж байсан. Одоо төлөвлөгөөний комисс гээд ярихаар хүмүүс их дургүйцдэг юм. Өнөө төлөвлөгөөт эдийн засаг гээд хуучин юм руугаа орох гэлээ гэж. Үндэсний хөгжлийн яам гэсэн бүтцийг Засгийн газарт зайлшгүй бий болгох хэрэгтэй. Ингэхгүйгээр тал тал тийш харсан, салбар хариуцсан яамдын ажил хоорондоо огт уялдахгүй. Бүр аргаа бараад Ерөнхийлөгч Үндэсний хөгжлийн цогц бодлогоо боловсруулна гээд эрдэмтэд мэргэдийг дайчлан ажиллаж байна. Эд чинь юмаа хийчхээд хэдэн төгрөг аваад явчих хүмүүс шүү дээ. Үнэхээр ийм бүтэц Засгийн газрын бүрэлдэхүүнд байхгүй байгаа явдал бол бидний бодлого зохицуулалтгүй явж байгаагийн нэг шалтгаан нь болов уу.

Ууганбаатар /”Парламент дахь иргэний төлөөлөл” хөдөлгөөний зохицуулагч/

Таны ярьж буй өөрчлөлтөөр яаж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг тэнцвэржүүлэн бие биеэс нь хараат бусаар ажиллуулах боломжийг олгох вэ?

Монгол Улс парламентын засаглалтай гэх боловч манай Үндсэн хуульд парламентын

засаглал гэсэн үг байхгүй. АНУ ерөнхийлөгчийн засаглалтай гэх боловч Үндсэн хуульдаа ерөнхийлөгчийн засаглалтай гэж бичээгүй байдаг. Та сая парламентын засаглал, ерөнхийлөгчийн засаглалын тухай ярилаа. Юуг засаглал гэж ойлгох вэ, үүнийг тодруулна уу? Шүүхийн засаглал гэж байж болох уу?

Засгийн бүх эрх ард түмний гарт байгаа гэдэг. Одоо Үндсэн хуулиа өөрчилдөг юм байж. Төрийн тогтолцоондоо шинэчлэлт хийдэг юм байж. Харин ард түмэн бид төрийг яаж хянах вэ?

Та нийтлэлдээ 76 гишүүнээсээ хоёр танхимаа гаргачихъя гэж бичсэн байсан. Энэ санал манай холбооны тавьж буй саналтай төстэй юм. Энэ талаар дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө үү?

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Олон хэмжээст орон зайд оршдог нийгэмд төр таван хэмжээстэй байдаг юм. Энэ тухай хамгийн сүүлд 1924 онд Суняций бичсэн. Зарим номд Суняцийн онол гэж ч бичдэг л дээ. Уг нь Монголын төрийн анхны бүтэц байгаа юм. Энэ таван салаа мөчрийг бий болгож тэдний хоорондын харилцааг тогтоож баймааж сая төр тэнцвэржин тогтворжих байх. Гэхдээ тэнцвэржинэ гэдэг ойлголт их сонин л доо. Энэ бол бие биеэсээ хараат бус байх тухай асуудал юм.

Парламентын засаглал, ерөнхийлөгчийн засаглал гэдэг бол онолын л асуудал. Аль ч орны Үндсэн хуульд манайх парламентын

засаглалтай, ерөнхийлөгчийн засаглалтай гэж бичдэггүй. Онолын асуудлын гол шалгуур нь Ерөнхийлөгч, Засгийн газраа парламентаас гадуур байгуулах гэдэг л асуудал. Америкийн ерөнхийлөгч нь Засгийн газраа толгойлоод явдаг. Жишээ нь, төрийн нарийн бичгийн дарга нь гадаад яамны сайд, ерөнхий сайдын үүргийг хувааж гүйцэтгэдэг шүү дээ. Тэгэхээр энэ бол онолын л асуудал. Бидний ярьж буй асуудлын гол цөмийг харахад зарим нь ерөнхийлөгч нь Засгийн газраа байгуулан толгойлоод явна гэдэг байдлаар ойлгож байна. Зарим нь ерөнхийлөгчийн засаглалтай болчихвол парламент хэрэггүй болчих юм шиг ярьж байна. Тийм биш л дээ. Гэхдээ ерөнхийлөгчийн засаглалын тухай ярихад нэг зүйлийг бодохгүй бол горьгүй. Саяхан Туркменийн ерөнхийлөгч өөд боллоо. Одоо Казакстаны ерөнхийлөгч насан туршийн ерөнхийлөгч гээд томилогдлоо. Гэх мэтийн янз бүрийн зүйл цаагуур чинь гарна шүү дээ. Тэр бүгдээс болгоомжилж бодох л хэрэгтэй. Ард түмэн засгаа яаж хянах юм бэ гэж. Ард түмэн засгаа хянана гэдэг бол олон янз. Нэгд, иргэний байгууллага хүчтэй байгаа нөхцөлд төрийн хазгай алхамыг тухай бүрт нь хянаад, хэлж чадна. Хоёрт, парламент дотор хэмжээлшгүй эрхтэй олонхийн ноёрхол тогтоохгүй, цөөнх нь олонхио хянадаг байвал болно. Энэ нь нэг алхам болно. Гуравт нь, сонгосон төлөөлөгчдөө эргүүлэн татах эрх. Энэ эрх манайд одоо байхгүй. Дөрвөн жил сайхан юм хэлж сонгогдчихоод дөрвөн жилийн дараа сонгосон гишүүн нь тойрог солиод явчихна.

Ийм байж болохгүй л дээ. Тойрог солихыг нь хориглох хэрэгтэй. Тойрог соливол дахиад нэр дэвшихгүй л байна биз дээ.

76 дээр хэдийг нэмж хоёр танхим болгож болно. Эсвэл 76-гаа 25, 51 хувааж болно. Өмнөх бага хурал 53 гишүүнтэй болж л байсан шүү дээ. Хуулиа гаргаад л байсан. Гэхдээ энэ бол чанарын л асуудал. Би нэг юмыг гайхдаг юм. Манайх санал хураана гээд бүгдийг нь нэг танхимд дуудаж байгаад нууцаар кноп даруулдаг. Энэ бол хяналтаас гадуур. Би Америкт Конгресийн гишүүн Крестин гэдэг өвгөнтэй уулзаж байсан. Тэр чи миний санал өгөхийг хар даа гээд би дагаж очлоо. Спикер нь байна, танхимд арваад хүн байгаа юм уу, мэдэхгүй. Америкийн төрийн албан хаагчид намын харъяалалгүй байх тухай хуулийг цуцлах асуудал дээр санал өгөхдөө Крестин урд нь очоод чангаар би зөвшөөрөхгүй ээ гэж хэлж байгаа юм. Спикер нь микрофоноо аваад Крестин татгалзлаа гэж танхим дүүрэн зарлаж байх жишээтэй. Энэ бол жинхэнэ парламентч хүний хариуцлагатай дүр төрх юм. Гэхдээ тэр хүн манайхан шиг бизнес хөөж яваад гаднаас орж ирээд саналаа өгч байгаа юм биш. Тэр хүний үүдэнд 16 туслах сууж байгаа юм. Тэд өндөр мэргэжлийн экспертүүд. Зөвлөгөө өгсөн тэднийхээ саналын үндсэн дээр өөрөө шийдвэрээ гаргаж байгаа юм. Ийм хариуцлагатай парламент хэрэгтэй. Одоо манайд парламентын гишүүн гээд бүхнийг мэддэг толгой байж болохгүй шүү дээ. Гэтэл тэр ороод саналаа өгч л байдаг. Хажууд нь

туслах нь гээд цай зөөдөг үүрэгтэй залуу, эсвэл, бүсгүй сууж л байдаг. Ямар парламент гэж үүнийг хэлэх вэ дээ.

Сосормаа /Багш/

Би төрийн захиргааны онол, менежментийн хичээл заадаг. Хэдэн зүйлээр санал солилцёе гэж бодсон юм. Манай төрийн шинэтгэл хүнээсээ хол байх шиг санагдаж байна. Өөрөөр хэлбэл, шинэтгэлийн төвд хүн байх ёстой. Хүний сэтгэхүй, хандлага, үзэл бодол өөрчлөгдөж байж шинэтгэл хэрэгжих ёстой. Наад захын жишээ ямар ч сурах бичиг алга байна. Төрийн тогтолцооны шинэтгэлийн сурах бичиг алга. Төрийн байгууллагын менежментийн сурах бичиг байхгүй байна гэвэл та бүхэн гайхах байх. Үнэхээр байхгүй байна. Энэ нь оюуны хомсдолыг авчирч ирж байна. Престройка яригдаж байх үед би Орост оюутан байсан юм. Тэгээд бид Оросын нэг өвгөнөөс “Та нар престройка гэж юу яриад байгаа юм бэ” гэж асуусан чинь “Энэ бол дээд тал нь шуугиж байдаг, дороо нам гүм байдаг их том ой юм” гэж хариулж байлаа. Түүн шиг санагдах юм.

Ардчилсан тогтолцоонд шилжиж төрийн байгууллагууд шинэтгэлд орсноос хойш багагүй хугацаа өнгөрлөө. Энэ хугацаанд бид юу хийв, юун дээр алдав, юун дээр онов, цаашид юу хийх хэрэгтэй вэ гэдэг дээрээ үнэлгээ хийх цаг болжээ. Энэ үнэлгээг үндэсний хэмжээнд явуулмаар байна. Америкийн жишээ хэлбэр. Клинтонь

үед дэд ерөнхийлөгч Гороор ахлуулсан үндэсний гүйцэтгэлийн үнэлгээ явагдсан. Тэд энэ үнэлгээнээс асар их алдаагаа олж харсан. Цаашид хийх, засч залруулах олон философийг гаргаж ирсэн байгаа. Таны тавьж буй энэ илтгэл бол нэг хүний санаа, судалгаа юм. Үндэснийх биш юм.

Төрийг хямралаас гарган хөгжүүлэх гол асуудал бол гурван Р гэж ярьдаг. Паблик, параяд, партнишип гээд төр, хувийн хэвшил, олон нийтийн түншлэлийн асуудал. Энэ түншлэл бодлогын түвшинд байх ёстой. Тэгээд хянаж байх ёстой. Саналаа оролцуулж байх ёстой. Гүйцэтгэлийн түвшинд байх ёстой. Хамтарч хэрэгжүүлэх ёстой. Тэгвэл иргэд төр байхыг сонирхохоо больж эхэлнэ. Төрд шургалж эрх мэдэлтэй байх сонирхол багасах болов уу гэж бодож байна.

Эцэст нь таны олонхийн дарангуйлал гэдэгтэй санал нэг байна. Олонхийн дарангуйлал гэдэг бол улс төрийн сэтгэл судлалын шинжлэх ухаанд бүлгийн сэтгэхүйн эмгэг гэсэн нэр томъёотой орж ирээд байгаа. Group thinking гэж. Юу гэвэл олонх гэдгийн ард хэдхэн олигархи байдаг. Тэр хүмүүс өөртөө хэрэгцээтэй мэдээллээ гаргаж байдаг. Бусад нь тэднийг яс дагадаг. Хэрэв дагахгүй бол хэдэн олигархийнхаа шахалтад ордог. Тэгэхээр олонхи гэдэг маш их осолтой. Одоогийн УИХ-ын даргатай холбоотой үйл явдал ч гэсэн бүлгийн сэтгэхүйн синдромын хамгийн тод жишээ болж байна. Үүнийг бид нар ярих хэрэгтэй байх аа.

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/
Паблик менежментийн онолын судалгааны янз бүрийн номууд бий. Харамсалтай нь үндэсний оюуны чадавхийн хүрээнд төрийн түүхийг судалсан, өөрийн нөхцөл байдлыг олон улсын онол судалгаатай хослуулан дүгнэлт хийх чадвар манайд сул байна. Бараг байхгүй гэхэд болно. Аль ч эрдэм шинжилгээний байгууллагын сэдэвт байхгүй. Тийм учраас төрийн судалгааны төв байгуулаач гэж байгаа юм. Хөгжлийн хүрээлэнтэй адил. Төр гэж юу юм, Монгол гэдэг чинь юу юм, бид яаж явах ёстой юм гэдгийг судалж олон улсын онол судалгаатай ойртуулах хэрэгтэй байх.

Үнэлгээ хийх нь зөв. Ийм замаар явах хэрэгтэй юм. Манай төрийн одоогийн ийм будлиантай нөхцөлд ийшээ алхам хийхгүй байх. Ний нуугүй хэлэхэд энэ саналыг төр хүлээж аваад хийж чадахгүй байх. Аль нэг улс төрийн нам нь зориглохгүй байх. Харин иргэний хөдөлгөөнд түшээд 2008 оны сонгуулийн дараанаас хийгдэх болов уу. Би өнөөдөр өөрийн санаагаа л олон түмэнд хүргэж байгаа юм.

Гурван Р-ийн асуудал гэж байна. Мэдээж ийм түвшинд хамтарч ажиллахад их соёл хэрэгтэй. Паблик нь байна, параяд гэхээр урд чинь хэн зогсч байна, нөгөө хэдэн тэрбумтан чинь ирээд арзайгаад зогсч байгаа шүү дээ. Аль ч намын удирдах зөвлөлд бүлэглэл гэхээр хэдэн баячууд нь зогсч байгаа. Тэгж байгаа партнишип

гэхээр ард талд нь юу гарч ирэх вэ гэдэг бас асуудал. Өөрийн чинь хэлдэгтэй санал нэг байна. Ер нь монголчууд бүгдээрээ л нэг зүгт санаа зовж хөдлөхгүй бол бид нэг эвгүй байдалд хүрчихээд байна шүү. Энэ байдал удаан үргэлжилбэл их түвэгтэй байдал үүснэ. Одоо олон улсын хэмжээнд эвгүй байдалд орооцолдож эхэллээ шүү дээ. Сая Асгатын мөнгөний ордоос болоод ямар асуудалд оров. Төмөртэйн ордоос болж ямар асуудалд орооцолдож байна. Бусад асуудал дараа дараагаасаа гарч ирнэ. Тэгээд энэ нь сүүлдээ юу болж хувирах вэ гэдэг их сонин.

М.Батсуурь /МУИС-ийн ХЗС-ийн багш/
Та өнөөдөр парламентын тогтолцоонд гарч ирж байгаа хямралын хамгийн гол чухал зүйл нь парламентын маш их эрх дарх гэж хэлсэн. Би түүнтэй 100 хувь санал нэг байна. Ардчилал өндөр хөгжсөн улс орнуудын Үндсэн хуулийг судалж үзэхэд парламент нь төрийн байгууллагыг томилдоггүй юм. Яагаад гэвэл парламент иргэний байгууллага байдаг. Иргэний байгууллага хэзээ ч төрийг томилдоггүй юм. Тийм учраас сонгоно гэж ярьдаг. Засгийн газрыг сонгоно, Ерөнхий сайдыг сонгоно, Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нарыг сонгоно гэж ярьдаг. Энэ томилгоотой холбоотой маш том хямрал байгаа гэдэгтэй санал нэг байна.

Таны судалгааны нэр “Монгол Улсын төрийн тогтолцооны одоогийн байдал, түүнийг хөгжүүлэх гол чиглэлүүд” гэсэн байгаа. Харин

таны өөрчлөлт хийх ёстой цэгүүдийг харахаар ардчиллын институци рүүгээ илүү анхаарсан байгаа юм. УИХ, парламент, Засгийн газар, төрийн байгууллагууд гээд. Гэтэл төрийн тогтолцооны өөр чухал институци нь эрх зүйт ёс гэж ярьдаг. Өөрөөр хэлбэл, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийн тогтолцоо руу чиглэсэн өөрчлөлт байхгүй болохлоор би гайхаад асуумаар санагдлаа. Энэ рүү шинэтгэл хийх хэрэгцээгүй гэж бодсон юм уу?

ҮХЦ-ийг бид шүүх гэж ойлгож байгаа.

Шүүхийн байгууллага хэзээ ч урьдчилсан хяналтыг тавьдаггүй. Урьдчилсан хяналт тавьж дүгнэлт гаргаад эхлэхээр шүүх биш болдог. Та энэ санаагаа Францын Үндсэн хуулиас авлаа гэж хэлсэн. Энэ бол үнэн. Франц ганцаараа ийм сонин загвартай. Үндсэн хуулийн зөвлөл буюу тербинал гэж ярьдаг. Франц бол 200 гаруй жилийн ардчиллын түүхтэй улс. Тавдахь бүгд найрамдах улс, 20 хэдэн Үндсэн хуулийн төсөл боловсруулж байсан, Үндсэн хуулийн лаборатори улс гэдэг. Францад улс төрийн соёл өндөр төлөвшчихсөн учраас дүгнэлт гаргаад өгөхөд түүнийг нь авч шийдээд байж магадгүй. Манайд ҮХЦ урьдчилсан хяналт тавьж дүгнэлт гаргаад өгвөл аваад, саналыг нь ерөөсөө харгалзахгүй шүү дээ. Шүүх байгаагийн ач гавьяагаар, шүүхийн шийдвэр эцсийнх байна гэдгээрээ өнөөдөр асуудал шийдэх гэж үзээд байна л даа. Би ҮХЦ-ийг шүүх байгаасай гэж хүсдэг. Тийм учраас урьдчилсан хяналт тавих нь зөв үү, буруу юу.

Сонгуулийн ерөнхий хороог ҮХЦ-д харьяалуулах нь зөв гэж та санал дээрээ тэмдэглэсэн байсан. Би үүний эсрэг саналтай байна. Хэрвээ ҮХЦ-ийг шүүхийн байгууллага гэж үзвэл ардчиллын давалгаанаас аль болох ангид байлгахыг эрмэлздэг. Ардчиллын давалгаа шүүхтэй хутгалдаад ирвэл тэнд дарангуйлал үүснэ. Монтескогийн онол нь ч тэр. Ганц онол нь ч биш, хүн төрөлхтний туршлага нь ч тийм байгаа юм. Тэгэхээр энэ шүүхийн байгууллагыг улстөржүүлэх шаардлага байна уу?

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Би түрүүн хэлсэн. Манай шүүхийн тогтолцоо бас л асуудалтай болчихсон. Манайхан чинь хээл хахууль гэж ярьдаг болж дээ. Дээр үеийн ном сударт хээл түлхүүлж, хахууль үмхэх гэж ярьдаг шүү дээ. Түүгээрээ нэгдүгээрт ороод явж байгаа. Ер нь ерөнхий шүүгч, ерөнхий прокурорыг томилох асуудлыг дээд танхимдаа, төрийн эрх барих дээд байгууллага гэдэг утгаа дээд танхимдаа хадгалах тухай л асуудал яригдаад байгаа. Парламент бол иргэний нийгэм байгууллага гэдэг нэлээн асуудалтай тулж очно л доо. Гэхдээ шүүхийн асуудал дээр нэлээн нухацтай хандаж шүүхийнхээ системийг яаж өөрчлөх вэ гэдгийг судлахгүйгээр шууд хэлэхэд учир дутагдалтай байна.

Үндсэн хууль бол хамгийн дээд хууль, тийм учраас бүгд дагаж мөрдөх ёстой. Дөрвөн жилийн хугацаанд 51 удаа Үндсэн хуулиа

зөрчиж байна гэдэг бол УИХ-ын гишүүд тангаргаа 51 удаа зөрчиж байна гэсэн үг. Үүнээс болж төрийн байнгын хямрал үүсэх нөхцөл бүрдэж байна. 250 саяын асуудлыг хэлэлцэхэд УИХ-ын дөрвөн гишүүнээс бусад нь саналаа өгсөн байгаа. 72 хүн нэгэн зэрэг тангаргаа зөрчлөө гэсэн үг биз дээ.

Францын хувьд жаахан өөр л дөө. Францын хуульд төрийн зөвлөл гэж байгаа. Төрийн зөвлөл дотор Ерөнхийлөгч байсан хүмүүс насан туршдаа гишүүн болоод явчихдаг. Тэнд оролцож явах жишээтэй. Ийм нөхцөлд экспертийн түвшинд Үндсэн хуулийн асуудлыг хянаж үзээд сүүлд нь бөөн маргаан гарч төр тэр чигээрээ хямралд орчихгүй л юм даа. Би ч гэсэн ҮХЦ-ийг шүүх л гэж үздэг. Маргааны асуудлыг тасалж байгаа утгаараа дээд шүүх.

Баярцэцэг /ННФ-ын менежер/

Тогтолцоотой холбоотой асуулт байна. Зарим хүмүүс одоогийн тулгарч буй бэрхшээл нь тогтолцоо гэхээсээ илүү хүнээсээ болж байгаа гэж ярилаа. Улс төрийн нам нь өөрөө шинэчлэгдээгүй цагт их түвэгтэй гэж хэлж байна. Хүний сэтгэлгээ нь өөрчлөгдөөгүй цагт ямар ч төрийн тогтолцооны өөрчлөлт хийхэд ялгаа байхгүй шинэхэн тогтолцоог бохирдуулах аюул байгаа юм биш үү гэсэн асуудал гарч ирж байна. Тэгвэл яаж шинэчлэлийг давхар хийж явах вэ?

Та иргэний хөдөлгөөн бол улс төрийн намын нэгэн адил улстөрийн талбарт сонгуульд

оролцох ёстой гэж хэллээ. Би энэ тал дээр жаахан эргэлзээтэй л байна. Яагаад гэвэл иргэний хөдөлгөөн хэдийгээр улс орныхоо сайн сайхны төлөө гэсэн намтай ижил зорилготой боловч тэдний арга барил, ажиллах талбар, тоглоомын дүрэм нь өөр байдаг. Тийм өөр байгаагаараа бахархаж аль болох ялгаатай байхыг чармайдаг. Энэ бол зөвхөн Монголынх ч биш, бусад орон ч гэсэн ийм байдаг. Тэгэхээр иргэний хөдөлгөөнүүд улс төрийн намын нэгэн адил байх ёстой гэсэн таны санааны цаана юу байгаа юм бол?

Та ҮХЦ-ийг иргэдээс сонгож болох юм гэж дурдлаа. Би үүнийг анх удаа сонсч байна. Их сонин санаа сонсогдлоо. Ингэснээрээ ямар ач холбогдолтой байх вэ? Бусад орны жишээ байна уу?

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Эхний асуудал бол төрд бэлтгэгдсэн хүний тухай асуудал. Би төрийн боловсон хүчнийг сонгох, шалгаруулах тогтолцооны тухай ярилаа л даа. Улс төрийн албан тушаалын тухай биш. Хэрэв сонгуулийн хуулиар намын удирдлагын явцуу бүлэглэлийн дарангуйллаас гадуур, хөрөнгө мөнгөөр хавчигдахгүй нэрээ дэвшүүлэх боломжийг нээж өгвөл Монголд чадалтай, боловсролтой хүмүүс бий байх. Хөдөөгийн нэг малчин өвгөн ч гэлээ манай их хурлын зарим гишүүнээс арай дээр байх гэж боддог. Тийм л асуудал юм.

Иргэний хөдөлгөөнд нам харгалздаггүй. Янз бүрийн намын хүмүүс ороод явж л байгаа. Жишээлбэл, Миний нутгийн газар шороо, Иргэний холбоо гэхэд янз бүрийн намын хүмүүс байгаа. Яагаад энэ хүмүүс олон түмний дунд бий болсон нэр хүнд, капитал ашиглаж 801 хүний гарын үсэг цуглуулж чадахгүй гэж. Харин ч боломжтой. Эд нар бол олон түмэнд танигдсан хүмүүс. Одоогийн хуулиар бие даагчийг нэр дэвшүүлнэ гэж байгаа шүү дээ. Харин УИХ-д орсон хойно нь зөвхөн намуудтай ярина гэдэг хаалтаа л авах хэрэгтэй. Энэ талаар онолын хувьд сонирхож байгаа хүмүүс Британийн шинэ нэвтэрхий толийн намын тухай заалт бичсэн тайлбарыг үз гэж хэлмээр байна. Бусад оронд иргэний хөдөлгөөн, холбоод нь намаас гадна бие даан сонгуульд ордог туршлага зөндөө л байна шүү дээ.

Цэцийг иргэдээс сонгох асуудал бол цэцийн хараат бус байдлаас л гарах гэсэн миний бодож олж байгаа арга. Үндсэн хууль бол төр засаг нь ард түмэнтэйгээ байгуулсан гэрээ. Би ийм байна шүү, харин та ийм байх эрхтэй гэж. Гэтэл энэ гэрээг сахих ёстой маргаан таслах хүний хэдийг нь тэндээс УИХ, тэндээс шүүх, тэндээс ерөнхийлөгч сонгодог. Тэгээд нам нь араас нь шахаж байгаад нэгийг нь дарга болгоод тавьчихдаг. Одоо нөгөөдөхөө зодож эхэлж байна шүү дээ. 2000 оны 7-р сарын 20-ноос 12-р сарын 14 хүртэл долоон сарын хугацаанд Монгол Улс Үндсэн хуулийн бус Засгийн газартай байсан. Үндсэн хууль

зөрчсөн гэсэн үг. Ийм байдалд оруулахгүйн тулд ард түмэн гэрээгээ сахих хүмүүсээ өөрсдөө сонгох боломжтой байх асуудал юм. Миний итгэж үнэмшиж явдаг зүйл гэвэл нэгэнт л ардчилсан нийгэм юм бол иргэн хүн зөвхөн хуулийн объект биш, төр өөрөө субъект байх ёстой. Тэр хүн төр барих хүмүүсээ сонгоод гаргаж чаддаг байх хэрэгтэй.

Зулькафиль /Удирдлагын академи/
Монтескьюгийн онолоор төр гурван салаа байдаг, харин дорны хандлага бол таван салаа байх юм гэж та ярилаа. Монтескьюгийн онолын дагуу гурван салааг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэж төлөөлүүлэн ойлгож байгаа. Таны ярьж буй таван салааны хоёр нь ямар институци юм бэ, тэдний функц нь юу вэ? Та Өгөдэй хааны үед тодорхой яамд байсан гэлээ. Хэрвээ яам хэлбэртэй болчихвол гүйцэтгэх засаглал руугаа ороод салаа биш, харин дахин нэг яам бий болчих юм уу гэсэн санаа байна.

Хоёр танхимтай байхын тулд онолын хүрээнд нэг бол холбооны улсын шинжийг илэрхийлэх ёстой, эсвэл, олон үндэстнээс бүрэлдсэн байх ёстой гэдэг. Гэхдээ өөр жишээнүүд бий л дээ. Тухайлбал, манайхтай адил посткоммунист орнуудаас Киргиз хоёр танхимтай. Манайд хоёр танхим хэрэгтэй юү, энэ нь ямар байх юм бэ? Учир нь хоёр танхимын давуу болон сул талын тухай их ярьдаг л даа. Давуу тал нь гэвэл хууль шүүгдэж маш сайн гардаг, сул тал нь зарим талаараа хууль тогтоох процессыг удаашруулдаг

гэдэг. 76 гишүүнтэй нэг танхимтай байхдаа саяын хаврын чуулганаар ганц л хууль баталлаа шүү дээ. Ийм байгаа нөхцөлд ахин нэг танхим нэмчихвэл хууль тогтоох процесс маань улам удаашрах юм биш үү.

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Таван салааны тухайд бол нэгдэх нь төрийн жинхэнэ албанд хүнийг сонгох, шалгаруулах, бэлтгэх тогтолцоо, хоёрдахь нь төрийн хяналтын тогтолцоо юм. Одоо Монголд хоёулаа бий. Төрийн албаны зөвлөл, Төрийн хяналтын хороо гээд. Төрийн хяналтын хороог анх байгуулахдаа яам, газар, аймаг, хотын засаг даргын тамгын газрууд хууль хэрхэн биелүүлж байгааг шалгах, түүнийг жигдрүүлэх тухай зүйл ярьж байсан. Сүүлд нь энэ байгууллага төсвийн зарцуулалтыг хянадаг хороо болчихоод байгаа юм уу даа. Сая УИХ дээр 59 тэрбум төгрөгийг чинь байхгүй болгочихож гэхэд УИХ тоох ч үгүй хараад л сууж байна. Тэгэхээр энэ хоёр байгууллагыг Үндсэн хуулийн институци байдлаар бусадтайгаа тэгш харьцдаг болгоогүй цагт засрахгүй нь ээ гэсэн ойлголт байгаа юм.

Өгөдэй хааны үед яам байсан гэж ярьж байна. Түүн дотор хоёр нь яам нэртэй, нөгөө тав нь төвийн бичгийн муж гэсэн нэртэй явсан. Ер нь дорны нийгэм бол олон хэмжээстэй. Та бүхэн мэднэ. Барууны үйлдвэржсэн нийгмүүд бол ягойст нийгэм. Манайхан гэхэд нэг

намаас сонгогдчихоод байхад нөгөө намын, нэг ангид байсан нөхөр нь, нэг бизнесийн холбоотон нь туслаач гэж давхиад очно. Одоо энэ хар л даа. MCS дээр АН-ынхан, Хувьсгалт намынхан бүгд л бөөгнөрчихөөд байгаа биз дээ. Тэр Энержи Ресурс дээр ч гэсэн бүгд л бөөгнөрчихөөд сууж байгаа. Хаа хаанаа тийм шүү дээ. Үүнээс гарах тухай л асуудал юм.

Хоёр танхимтай болчихоор хууль боловсруулах явц удаашрах болов уу гэлээ. Синхрон зэрэг хэлэлцээд явахад удаашрахгүй. Харин нэг нь хэлэлцэж тавьчихаад нөгөөдөх нь жилд хоёр удаа чуулна гэвэл хууль тогтоомж удааширна л даа. Гэхдээ чанаргүй олон хууль гарснаас чанартай нэг хууль гаргасан нь дээр. Бид 300 гаруй хуультай болоод байна. Нэг удаа удаашрах хэрэгцээ ч бий болсон байж болох юм.

Г.Уранцоож /“Хүний эрх хөгжил” төв/

Манайх 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжихэд хүн амынхаа нэлээн хувийг ядууруулчихсан шүү дээ. Тэгээд зах зээлийн эдийн засагт шилжиж хувийн хэвшлийг дэмжсэнээр хувийн аж ахуйнууд, капиталистууд бий болжээ. Тэд хуримтлал хийгээд байна. Нэг нь хуримтлаад байгаа нөхцөлд нийт бүлэг хүмүүс ядуурах нь гарцаагүй санагдаад байгаа юм. Тэгээд одоо явсаар бага хэмжээний хувийн капиталистууд биш, бүр том олигархи бүлгүүд үүсээд хэдхэн хүний гарт нийгмийн баялаг төвлөрөх хандлагатай болчихоод байна. Харин

ядуучуудад гадны тусламжаар л хэдэн юмыг хуваарилж өгдөг болохоос яг ядуурлаас гарах арга зам нь харагдахгүй байна. Тэгээд арван хэдэн жил ядуурал буурсангүй. Энэ нийгмийн хөгжил чинь хуримтлал, хуваарилалт гэсэн хоёр туйл баймааргүй, дунд нь ямар нэгэн аятайхан юм байх ёстой ч юм шиг. Нэг талд нь хуримтлуулж байхад нөгөө талд нь хувааирилж байх ёстой юм шиг санагдах юм. Тэгэхээр хуваарилалтыг яаж гаргах юм бэ. Төрийн тогтолцооны шинэтгэлийн чиглэлд хүмүүсээ ядуурлаас гаргах арга зам нь юу байж болох вэ? Хуримтлал, хуваарилалтыг яаж зөвөөр балансжуулах вэ?

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Би өөрийнхөө ойлголтыг хэлье. Бид социалист тогтолцооноос салахаас өөр арга байхгүй. Одоо Хятадын онцлогтой социализм байна. Куба социализмаасаа салаагүй явах шиг байна. Хойд Солонгос бас байна. Бидэнд өөр зам байхгүй. Хүн төрөлхтний нийтлэг замыг нь дагаж явж л бид хөгжил дэвшилд хүрэх ёстой. Одоо дэлхийн өндөр хөгжилтэй орнууд бүгд л энэ хуримтлал бий болгодог хувийн өмчид тулгуурласан замаар л явсан. Гэхдээ хүнээ боломжийн амьдрах хангамжийн талаас нь бодоод үзэхэд нүдэн дээр тов тодорхой гарч ирж байна. Одоогоос гурван жилийн өмнө Монголын нэг хүнд жилд дунджаар 465 долларын ҮНБ ногддог байсан. Өнгөрсөн жил 1019 болоод ирлээ. Хоёр дахин нэмэгдлээ. Тэр мөнгө хаачсан бэ. Манай

капиталистууд аваад шууд хуримтлаагүй юм. Хяналтгүй, ард түмнээсээ тасархай манай төр нөгөөдөхөөрөө баахан төсөв бүрдүүлж аваад хуваарилж эхэлсэн. Хэрэв бид Үндсэн хуульдаа санхүүгийн засаглал гэсэн бүлэг нэмж, төрийн зардал нь үндэснийхээ эдийн засгийн өсөлтөөс түрүүлж болохгүй гэсэн зарчмаа түүн дотроо тогтоож аваад үлдсэнийг нь цалин хангамжаа дээшлүүлэх зүйлдээ зарцуулах чиглэлийг гаргаад өгвөл энэ иргэний нийгмийн зам дээрээ бид тэгш сайхан амьдрах боломжтой гэж би боддог. Одоо Монгол Улсын ҮНБ нь энэ жилийн байдлаар 3 триллион 400 тэрбум төгрөг орчим болох төлөвтэй байгаа. Гэтэл триллион 400 тэрбумыг нь улсын төсөвт бас л зарах нь байна. Одоо юунд зарж байгааг нь бид харж байгаа. Энэ юуг харуулж байна вэ гэвэл манайд гажуудалтай иргэний нийгэм тогтож байна. Ийм учраас төрөө ард түмнийхээ хяналтад оруулъя. Тэгвэл зөв болох байх. Түүнээс ухрах зам байхгүй.

Р.Бадамдамдин /УИХ-ын гишүүн/

1992 онд бид шинэ Үндсэн хуулиараа их том реформ эхлүүлсэн. Өмнө нь МАХН-ын удирдлаган дор социализм, коммунзмзыг байгуулна гэсэн чиг үүрэгтэй явж байсан. Түүнээс хойш төр бол иргэний ардчилсан нийгмийг байгуулна, иргэдэд үйлчилнэ гэсэн үзэл санааны дагуу бүх хууль дүрмээ өөрчилж арван хэдэн жил болж байна. Гэтэл хүний сэтгэхүйд ч, нийгмийн сэтгэл зүйд ч байдаг нэг инерци яваад байгаа юм. Хүн чинь нэг ойлгоод авсан юмнаасаа салах дургүй байдаг.

Үнэхээр баримттай юм хэлээд байсан ч гэсэн ийм биш дээ гэдэг. Энэ инерцийн нөлөөгөөр батлагдаж буй хуулиудад Үндсэн хуулиа зөрчсөн жаахан жаахан заалт, цэг, таслал, үзэл санааны юм ороод байгаа нь ажиглагддаг. Төрийн чадавхийг нэмэгдүүлье, төрийн чадамжийг дээшлүүлье, төрөө дээдэлдэг монголчуудын сайхан уламжлалаа хадгалья гэсэн үг яриа тасралтгүй яваад байдаг. Хуулийн өмнө очиход төр нь иргэнийхээ дээр гарах жаахан жаахан заалтуудыг хийж өгөөд байгаа юм. Ингэсээр байгаад Үндсэн хууль зөрчсөн энэ юмнууд чинь гараад ирдэг. Сүүлд нь Үндсэн хууль амьдралд таарахгүй байна гэдэг асуудал руу явчихаж байна гэж би ойлгож байна. УИХ-ын дарга Нямдорж Үндсэн хууль зөрчөөд түүнийгээ хүлээн зөвшөөрөхгүй байна гэдэг чинь цаанаа суурь байгаад байна. Нэгдүгээрт, нийгмийн сэтгэл зүйн инерцийг ашиглаж байна, хоёрдугаарт, хууль зөрчөөд явсан давтамжууд нь ийм юм байдаг шүү дээ гэсэн юмыг өгөөд байна. Энэ дээр реформ зогсоод өөрчлөгдөхгүй байгаа юм.

Ер нь төр бол өөрөө өөрийгөө бэхжүүлдэг дарангуйллын механизм шүү дээ. Боломж олдох бүрт өөрөө өөрийгөө бэхжүүлж өөрийнхөө хүч чадал, эрх мэдлийг дээшлүүлж байдаг мөн чанартай. Тэгэхээр төрийн энэ мөн чанарыг зөнд нь орхичихвол үүнийгээ үргэлж хийх болно. Тэгсээр байгаад дарангуйлал руу алхам алхамаар явчихдаг байгаа юм.

Сүүлийн хэдэн жил реформууд зогсчихоод байна гэдгийг олон нийт, иргэний хөдөлгөөнийхөн дуу хоолойгоо гарган шаардаж байгааг зөв гэж боддог. Ямар реформууд вэ. Төрийн тогтолцооны асуудал байна. Хоёр танхимтай болох уу, ерөнхийлөгчид эрх мэдэл өгөх үү, үгүй юү гээд яриад байна. Ер нь ардчилал бол балансын л асуудал. Төрийг удирдах их сайн хүнийг олж сонгоно гэхээсээ илүү хажууд нь хянадаг баланс байх хэрэгтэй. Парламент ч ийм утгаар үүссэн шүү дээ. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын хоорондын эрх мэдэл ч гэсэн ийм баланс руу чиглэж байна. Түүнээс биш тийм идеальний хүн нэг удаа олоод тавигдаж болно. Гэтэл амьдрал мөнх үргэлжилнэ. Үргэлж тийм хүн олоод байхгүй. Ардчилал гэдэг хэдий сайн зүйл биш ч гэсэн хамгийн гайгүй тогтолцоо гэж ойлгоод байгаа шүү дээ.

Сонгуулийн реформ хийх шаардлагатай байна. Өмнө нь ямар сонгуулийн систем үйлчилж байсан бэ гэвэл хэлбэрдэх юм. Бүх ард түмнийг төр барихад оролцуулж байгаа юм шиг хэлбэрдсэн сонгуулийн систем үйлчилж байлаа шүү дээ. 400-500 тойрогтой, тэр тойргоос нь нэг хүн сонгогдоно. Тэгээд төрөөс явагдаж буй ажлыг дамжуулан нөгөө хүнд хүргэж, та нарын санал бодлыг ингэлээ гэж хэлбэрддэг байсан. Яг энэ хэлбэрдлийг үргэлжлүүлээд 76 тойрог болгочихсон. 76 хүн нь тойрогтоо баригдаад баахан амлалт өгдөг, нөгөө амлалтаа биелүүлэх гээд баахан төсөв цуглуулдаг гээд. Өмнөх

уулзалт дээр Бямбасүрэн гуай ярьж байсан. Та нар одоо социализм байгуулаад байна, бидний үед төсвийн хэмжээ GDP-гийн 30 хувь байсан бол одоо 50 хүрэх гээд байна гэж. Энэ бол үнэхээр тийм. Сонгуулийн систем нь тийшээ түлхээд байна. Сонгуулийн реформ хийж амлалт руу түлхдэг, төсөв томруулдаг байдлаас зайлсхийх хэрэгтэй.

Засаг захиргааны реформ хийгдээгүй. Өөрчлөлт байдаггүй. Одоо бид орон нутагт баахан эрх мэдлийг нь өгч нэг үзээд, төвлөрүүлж нэг үзээд энэ баахан зөрчлөө давж чадахгүй яваад л байна. Засаг захиргааны реформыг зоригтойхон шиг хийчихмээр байгаа юм. УИХ дээр хэрэлдээд байна, та нарыг солино гэж, эсвэл ерөнхийлөгч болохгүй байна шинэ ерөнхийлөгч гаргана гэж биш, энэ бүх үйл ажиллагаа ил тод байх зам руугаа явах нь чухал юм. Энэ тал дээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, одоо хэрэгжих гэж байгаа орлогын мэдүүлэг нээлттэй болгох явдал их нөлөөтэй. Энэ бүхэн нь ил тод байж, ард түмэн алган дээрээ тавьсан юм шиг харж байх юм. Энэ том реформ одоо хийгдэж эхлээд байна. Би түрүүчийн дөрвөн жилд Үндсэн хууль зөрчөөгүй, УИХ-ын дарга нь Нямдоржоос сайн дарга байсан гэж ойлгохгүй байна. Яагаад гэвэл түрүүчийн дөрвөн жилд мэдэгдэхгүй л байсан. Хяналт байхгүй, хэвлэлүүд чөлөөтэй нөвтрүүлж чадахгүй, томоохон асуудлыг босгож тавьдаг сөрөг хүчин байгаагүй. Иргэний хөдөлгөөнүүд ажиллах нөхцөл нь бүрэлдээгүй байсан. Ийм байдлаас болж дарагдаж байсан болохоос дарга

нар нь ямар ч хууль зөрчихгүй явж байгаад одоо Нямдорж дарга хууль зөрчөөд байгаа гэж ойлгохгүй байна.

Төсвийн реформоо хийхгүй бол болохгүй ээ. Буцаад яг социализм шиг төсөвтэй болж байна. Эргээд хуваарилалт нь давамгайлж байна. Ажил хийх чадвартай, эрүүл саруул, 20-30 настай залуучууд улсаас тэжээлгэх сэтгэлгээнд аль хэдийнэ автчихаж. Энэ нь сонгуулийн үед нөгөө хүмүүстээ саналаа худалдах гэдэг юм руу орж, баахан мөнгөтэй хүмүүс УИХ-д дэвшдэг гэсэн шүүмжлэлийг бий болгож байна шүү дээ.

Л.Ламжав /Иргэн/

Их хэцүү сэдвийг сонгож аваад өөрийнхөө үзэл бодлыг их зоригтойгоор илэрхийлж байгаад биширч байна. Энэ бол үнэхээр хэцүү асуудал. Хэрвээ ННФ-д бололцоо байдаг бол бид мэтийн ахмад хүмүүс илтгэл тавихын зэрэгцээ залуу үеийг оролцуулах маягаар хослуулбал харилцан бие биеэ ойлгоно. Нэг тал нь илтгэл тавьчихаад нөгөөдүүл нь дөнгөж сөхөж хараад, эсвэл, ярьсныг сонсоод санал бодлоо илэрхийлэхэд тухайн асуудал нэг их сайн хэлэлцэгдэхгүй байна. Тийм учраас ингэвэл илүү үр өгөөжтэй байх аа. Яагаад гэвэл залуучууд хойч үеийг авч явна. Миний оролцоо бол насны эрхээр дуусч байна шүү дээ.

Манайд болохгүй байгаа нэг зүйл бол нь парламентын оролцооны асуудал юм.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг энд баахан яриад дараа нь УИХ-аар орж байна. Энд хэлэлцэж байхдаа сайжруулна, засна гэж яриад байсан мөртлөө УИХ-д очихдоо юу ч засаагүй, яг хэвээр нь барьж байгаа юм. Энд ярьсны зорилго нь оролцсон гэсэн нэр авахын тулд юм уу даа. Тийм байж болохгүй. Тэр хууль төрийн байгууллагаас мэдээлэл авах эрхийн тухай хууль байвал илүү зүгээр байгаа юм. Мэдээллийн эрх чөлөө гэдэг чинь аягүй том асуудал. Их том хүрээтэй. Тэр хүрээгээ хамарч хуульчилна гэвэл хүч хүрэхгүй. Зүүн Европын орнуудад тийм хууль гаргасан гэсэн дуулианаар манайх дагаад байгаа юм. Тэд тийм нарийн хуулийг гаргаж чадна гэдэгт би итгэхгүй байгаа. Гаргасан ч гэж бодохгүй байна. Оролцоо хаягдаж байгаа учраас хууль нь муу гарч байгаа юм. Жинхэнэ ёсоор биш, зүгээр нэр барих замаар хандаж байна. Ялангуяа ННФ нэрээ буруу юманд битгий ашиглуулж бай гэж захимаар байна.

Илтгэлээс маш болгоомжтой хүлээж авч буй зарим зүйлийг хэлье. Нэгдүгээрт, ҮХЦ байна. Энэ байхгүй болбол Үндсэн хууль гэж шүдгүй арслан болж одоогийнхоосоо ч бүр дор хариуцлагагүй байдалд шилжиж магадгүй. Би энэ илтгэлийг бүрэн уншаагүй учраас нөхсөн зарим зүйлийг нь ойлгоогүй хоцорсон байж магадгүй. Хэрэв тийм бол уучлаарай.

Францын Үндсэн хуулийг их сайхан хууль гэж ойлгох хэрэггүй юм. Тэндэхийн парламентад

хориод жил ажилласан Васинет гуайтай би намын шугамаар ажиллах болсон юм. Тэр их туршлагатай хүн байсан. Францынхаа Үндсэн хуулийн зовлонг тэр үед ярьж байсан. Тэнд ерөнхийлөгч нь байсхийгээд парламентаа хөөгөөд тараачихдаг. Ерөнхийлөгч нь маш их эрх мэдэлтэй. Тэр үүнийг л нэг болиулчих юмсан, тэгвэл гайгүй болчих гээд байгаа юм гэж ярьж байсан. Манайхан халамжийн мөнгө амлаж байна шүү дээ. Үүнийг Францын Үндсэн хуулиараа аягүй хатуу хязгаарлачихсан байгаа юм. Тийм учраас манайхан шиг тэдэн төгрөг өгнө гээд сонгуульд амлавал цаашаа явах ямар ч нөхцөл байхгүй. Францын Үндсэн хуулийн зөвлөл гэдэг их алдартай зөвлөл. Түүхэн урт удаан хугацаанд их төлөвшсөн. Тэнд хуулийг шалгаж үзээд Үндсэн хууль зөрчөөгүй байна гэсэн дүгнэлт өгснөөр хууль нь хүчин төгөлдөр болдог. Манайд үүнийг авч хэрэгжүүлбэл хамгийн гайгүй хуулийг ч гэсэн Үндсэн хууль зөрчсөн гээд эхэлнэ. Зовлонтой тулаагүй байхад үүнийг хийсвэрээр шинэчлэх их хэцүү асуудал.

Манайд Засгийн газрыг унагах сонирхол байдаг юм. Улс төрийн тэмцэл угаасаа л тийм юм чинь. Германы Засгийн газрыг бүрдүүлэх механизм нь ерөнхий сайдаа парламентаас томилно, Ерөнхий сайд нь сайд нараа томилж Ерөнхийлөгчдөө танилцуулаад итгэл хүлээлгэж өгөөч гэж парламентдаа оруулдаг. Манайд маш олон албан тушаалтныг толгой дараалан томилдог. Энэ нь бөөн будлианд

оруулж байгаа юм. Үндсэн хуульд засах ёстой заалт бол Засгийн газрын гишүүдийн талаас илүү нь Ерөнхий сайдаа огцруулна гэж санал оруулдаг заалт юм. Хамгийн гутамшигтай заалт. Энэ мэтийг засах ёстой байх аа.

Ж.Эрдэнэчимэг /МЭХ/

Зөвхөн өнөөдөр хэлэлцэж буй гэхэд их олон асуудлыг хамарсан байна. Асуудал тус бүрээр судлаачид болон төр, нийгмийн зүтгэлтнүүд, тодорхой байгууллага, хувь хүмүүсийн байр суурь олон янз байдаг юм байна. Энэ лон янз байдлын цаана бас дутагдалтай болон давуу талууд байна. Иргэний нийгэм энэ зайлшгүй ахиц өөрчлөлтийг механизмд тулгах нөлөөллийг нийгэмд улс төрд үзүүлэх үүрэгтэй гэж ойлгодог. Өнөөдөр хэлэлцэж байгаа цуврал лекцүүдийг үндэсний цогц бодлого боловсруулан батлах энэ үйл явцтай холбон, түүн дотроо тодорхой асуудлыг оруулж, нийгэмд ахиц өөрчлөлт гаргах хөшүүрэг болгон ашиглаж болох юм. “Төрийн тогтолцооны одоогийн байдал, түүнийг хөгжүүлэх гол чиглэлүүд” гэдэг энэ сэдвийг үндэсний зөвшилцөлд хүргэх ямар механизм байж болох вэ? Одоогийн тавьж буй лекц төдийлөн хангалттай биш юм, өөр олон асуудал бий гэдэг нь ойлгомжтой. Жишээ нь, ҮХЦ гэдэг нь шүүх байх ёстой юу, эсвэл, хуучин нийгэмд прокурорын ерөнхий үүрэг байсан хяналтын үүргийг давхар авч явах ёстой юм уу, ерөнхийлөгчийн улс төрийн эрх үүргийг өргөжүүлэхэд хаант засаглалаас ямар ялгаатай юм бэ гээд иргэний нийгэмд, түүнчлэн

иргэн хүнд чиглэсэн улс төрийн ойлголтыг батжуулах талаар илүү гүнзгий ажил хийх шаардлагатай байна. Тийм учраас ахмадуудын туршлагатай санаа, залуучуудын шинэлэг санааг оролцуулан их сайн түвшинд бэлтгэж, үндэсний хөгжлийн цогц бодлоготойгоо холбон, үндэсний зөвшилцөлд хүрэхүйц, нийгмийн бүх төлөөллийг оролцуулсан форум зохион байгуулбал тодорхой зүйлийг хийх механизмд тулах гарц байж болох юм.

Ш.Гунгаадорж /Ерөнхий сайд асан/

Өнөөдрийн илтгэл бол их чухал юм. Нийгэм бухимдаж байгаа үед зарим нэгэн хариултыг өгөх, шийдлийг гаргахад ямар нэг хэмжээгээр санаа төрүүлсэн юм болж байна. Илтгэлээс гурван зүйл дээр анхаарал төвлөрөх ёстой гэж бодож байгаа.

Нэгдүгээрт, парламентын засаглал, ерөнхийлөгчийн засаглал байна уу, нэг танхимтай, хоёр танхимтай байна уу, хүссэн ч, хүсээгүй ч Үндсэн хууль руугаа орох асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр энэ нь Үндсэн хууль руугаа орох уу, яаж орох вэ, эсвэл хоёр танхим гэдгээ тойруулж ярих уу гэсэн нэг бүлэг асуудал байна. Механизмын асуудал бол нарийн зүйл л дээ. Хоёрдугаарт, ерөнхийлөгчийн үүрэг роль их том байгаа. Энэ хэр их зохимжтой юм бол оо. Ерөнхийлөгчийн засаглал руу хандуулсан юм уу гэсэн нэг бодол байна. Үүнийг бас л бодох асуудал. Гуравдугаарт, намуудын үүрэг хэрэгтэй, хэрэггүй гэж ярьцгааж байна. Намууд муу

байгаа нь үнэн л дээ. Арчаагүй байгаа нь ч үнэн. Гэхдээ энэ нь нам хэрэгтэй, хэрэггүй гэдэгтээ тулж ярих асуудал мөн үү, биш үү. Харин баруун, зүүн тийшээ хазайчихалгүй голд нь тогтоож, зөв механизмыг олж томъёолох асуудал юу байдаг юм бол.

Үндсэн хуулийн тухай хоёрхон зүйл ярья. 1992 онд баталсан Үндсэн хуулийг муу гэж би үздэггүй. Бид бүгд тэнд сууж 76 хоног хэрэлдсэн л дээ. 430 хүн шуугиж байж баталсан хууль гэхэд харин ч их ардчилалтай, зөв буруугаа чөлөөтэй ярьж, гараад явах гээд эргээд асуудал дээрээ тогтож ярих замаар баталсан хууль л даа. 1990 оны ардчилсан сонгууль бол Монголын түүхэнд анх удаа болсон олон намын оролцоотой сонгууль. Тэгсэн мөртлөө их ардчилсан, өнөөгийн явуулж байгаа сонгуулиас шал өөр байсан. Маш тайван явсан шүү дээ. Мөнгө төгрөг эсэн бусын юм тараагаагүй, түүнийгээ ч мэддэггүй байсан байх. Жинхэнэ ардчилсан сонгууль болж 430 хүн гарч ирсэн. Тэр хүмүүс энэ хуулийг баталсан юм. Цаашид хоёр танхимтай парламенттай болж, түүнийгээ төлөвшүүлэх хэлбэрээр явах нь дээр болов уу. Энэ илтгэлд сонгомол парламентын хэлбэрээр дээд, доод хоёр танхим байгуулах гэж байгаа. Миний санал бол АИХ, Бага хурал гээд юу гэж нэрлэх нь хамаагүй, тэр л зарчим.

Үндсэн хуулийг өөрчилнө гэж өнөөдөр ярьж байна. Энэ бол мөдгүй ээ. Лав л энэ УИХ-ын үед хийгдэхгүй асуудал. 2008 оны УИХ яаж

бүрдэх юм, бүү мэд. Өнөөдөр харанхуй байна. Тэгэхээр өнөөдөр тулгамдсан асуудал бол 1999- 2000 оныг дамнуулж хууль бусаар хийсэн тэр өөрчлөлтийг УИХ-ын гишүүн та нар байгаа үедээ горимд нь оруулж, хуучин Үндсэн хуулийг хэвээр нь болгож өгөөч ээ. Үүнээс болж маш их юм үүссэн. УИХ-ын гишүүн Засгийн газрын сайд болдог, намын үүргийг өндөржүүлсэн гээд. Цаана нь том асуудал яригдаж байгаа. Гэхдээ үүнийг хийчихвэл нэлээн юмны ир дарагдах учиртай юм. Хэрвээ үүнийг өөрчилвөл УИХ-ын том гавъяа, ард түмэнд хийх том буян болно шүү.

П.Жасрай /Ерөнхий сайд асан/

Монголын төрийн доройтол сүүлийн 5-6 жил явж ирлээ. 1996 онд Монголын төрд хогийн ургамлын үр цацагдсан. Одоо яг ид цэцэглэлтийн үедээ явж байна гэсэн дүгнэлтийг би бүрэн дэмжиж байна. Түүний учир юу гэвэл 1996 оны сонгуулиар бизнесийн бүлэглэлүүд анх удаа улстөрийн хүрээнд түрж орж ирсэн. Тэндээс улс төр, бизнесийн тодорхой бүлэглэл үүсч энэ үеэс Монголын төр яах аргагүй доройтол руугаа явчихсан юм гэж энд тэмдэглэсэн байна лээ. Үүнтэй санал нэг байна.

Төрийн доройтлын сүүлийн 17 жилд нэр хүндийн хувьд бараг үзэгдээгүй шахуу тийм байдалд өнөөдөр Монголын төр орсон байгаа. Та нар бүгдээрээ ард түмний дунд явж байдаг. Над шиг тэтгэврийн, гудамжинд алхаж явдаг өвгөнийг дэлгүүрт зогсч байхад, зах дээр явж байхад, тэтгэврээ авах гээд оочерлож байхад

олон нийтийн ярианы сэдэв энэ л байна. Тэгэхээр Монголын төрийн нэр хүнд өнөөдөр хамгийн доод шатандаа байгаа гэдгийг хариуцлагатай ажил хийж байгаа хүмүүс, юм бодож байгаа хүмүүс анхаарах ёстой байх. Үүнээс уламжилж ард түмний дунд их бухимдал үүссэн. Асар их бухимдал байна. Энэ бүхнийг илтгэлд маш оновчтойгоор хэлжээ. Би зургаан зүйлийн санал бичиж өгсөн. Үндсэндээ авсан байна. Аваагүй ганц нэг юм бий. Түүгээр саналаа хэлье гэж бодсон юм.

Саяхан Аденаурын сангийн суурин төлөөлөгч Фогел Энхбаяр ерөнхийлөгчтэй уулзахдаа Зүүн Германы коммунистуудын хийсэн гайг Герман улс бүхлээрээ хөдлөөд 17 жилийн дотор яаж ч чадахгүй байна гэж ярьсан байна лээ. Германы дөрөвний гурав нь цаанаа, дөрөвний нэг нь наанаа шүү дээ. Цаад тал нь их өндөр хөгжилтэй. Гэтэл 17 жил шийдэж чадахгүй байна гэж. Хүний толгойд суучихсан юмыг гаргана, зан заншлаас нь салгана, шинэ нөхцөлд дасгана гэдэг чинь хүний дур зоргийн юм биш байдаг бололтой юм.

Барууны нэг эдийн засагч бичсэн байна лээ. Социалист байсан орнуудад шилжилт хэзээ дуусах вэ гээд юутай ч гэсэн Зүүн Европын орнуудын ДНБ-ий үйлдвэрлэл нь тухайн үедээ дэлхийн зах зээлийн дундажид хүрч байж л сая шилжилт дуусна гэж. Энэ нь эхэлснээсээ хойш 40 жил юм уу даа. Тийм барагцааг хэлсэн байна лээ. Тэгэхээр Монголд энэ нь ямаршуу

хугацаатай байж таарах вэ гэдэг нь бидэнд нэг юм бодогдуулаад байгаа хэрэг. Бид тэднээс дор байсан. Түүнийгээ нэг бодох байх.

1997 оны үед Монголын төрийн удирдлагын чадавх илэрхий суларсан байсан. Тэгээд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй ярьж жаахан мөнгө төгрөг гаргуулан фокус ирж ажиллаж, талийгч Энэбишийн толгойлсон ажлын хэсэг Монголоос гарч яагаад Монголын удирдлагын чадавх доройтчихов оо гэдгийг тэд гурван зүйлээр хэлсэн. Хувьсгалт нам гээд хараагаад байх юм. Тэр чинь нам биш төр байсан юм байна гэж. Өөрөөр хэлбэл, төржчихсэн нам байж. Тэр нам гурван гол үүрэг гүйцэтгэдэг байж. Энэ нь хэтийн бодлого боловсруулдаг байсан, хүний хөгжлийн асуудал буюу боловсон хүчнээ шийддэг байсан, бүх төрлийн хяналт гарт нь байсан гээд. Гэтэл 1990 онд Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж МАХН бол Монголын нийгмийн удирдан чиглүүлэх хүч мөн гэдгийг авч хаяад энэ гурвын оронд төрийн ямар байгууллагыг оруулах билээ гэдгээ ерөөсөө мартчихсан. Оруулаагүй. Түүгээр ч зогсохгүй Үндсэн хуулийн 1990 оны өөрчлөлтөөс прокурорын ерөнхий хяналтыг хүртэл авч хаясан. Ингээд бүх юм хяналтгүй, боловсон хүчний бодлогогүй, хаашаа явах нь тодорхой биш болохоор ой дотор орчихсон чиглэлээ олж чадахгүй байгаа зээр шиг болчихсон улс л даа. Үүнээс болж Монголын удирдлагын чадавх унажээ. Тодорхой жишээ бол Барилгын зургийн институт юм. Манай

шинжлэх ухааны хэчнээн сайхан том төв байлаа даа. Сайн дураараа 23 компани болсон. Түүний нэг нь орос биллъярд тоглуулдаг компани байж байгаа. Баянцогтын САА мөн адил. Комбайны жолооч нь дарга, авгай нь нягтлан гээд 20 гаруй юм болчихсон. Ингэж утга учиргүй задрал явагдаад үүнээс болж бид их алдсан юм. Энэ үндсэн дээрээ яриад зөвлөмж гаргаж шугамын яамдыг аж ахуйн бодлогоос салгаач, төр өмчөө гартаа хийж аваач, тэгэхгүй бол наадах чинь яг тэр зургийн институт, Баянцогтын САА шиг юм болох нь ээ гэсэн. Нэгдэх зүйл нь тэр. Түүнийг хийхийн тулд ТӨХ байгуулж Төрийн өмчийн тухай хууль гаргасан хэрэг. Тэгээд ТӨХ-гоо байгуулж амжилгүйгээр бидний бүрэн эрхийн хугацаа дууссан юм.

Хоёрт нь, хяналтын юмаа жаахан цэгцэлье гээд төрийн хяналтын хууль гаргаж Төрийн хяналтын хороо байгуулсан. Одоо аудит хийдэг газар болчихоод байгаа юм уу даа. Ингээд жаахан гажаад явчихсан. Мөн төрийн албаны захиргаа байгуулсан. Ерөөсөө төрийн захиргааны албан хаагчдад нам хамаагүй, ерөөсөө карьерийн журмаар явна, үүргээ гүйцэтгэнэ гэсэн. Энэ маань бас явц муутай байна. Үүнийг манай нөхдүүд анхаараасай.

Дараачийн асуудал бол бид зарим үед аргагүйн эрхэнд Үндсэн хуульд гар хүрсэн. Би түүний нэг гэрч нь байгаа юм. 1999 оны 12-р сард 20 минутийн дотор баахан өөрчлөлт оруулсан гэж яриад байна шүү дээ. Батлах нь 20 минут

болсон нь үнэн. Яагаад гэвэл зургаан сарын хугацаа нь болчих гээд сандаргаад байсан юм билээ. Боловсруулах нь нэлээн удаан явсан шүү. Түүхэн нөхцөл байдал нь тэр үед түүнээс өөрөөр шийдэх аргагүй байсан юм. Ардчилсан холбоо эвсэл засгийн эрхэнд олонх байлаа. Дотроо баахан бүлэглэл болоод хуваагдчихсан. Элсний 13, хуучин соцдекүүд гээд, юу юу билээ. Тэгээд бие биеэ ээлжлэн түлхэж унагаагаад болдоггүй. Дөрвөн жилийн дотор дөрвөн Засгийн газар байгуулчихлаа, 40 гаруй сайд томилчихлоо. Ингэж хөгийн явдал болсон байхгүй юу. Дараа нь Да.Ганболдыг ерөнхий сайд болгох гэж ерөнхийлөгчид олонхоос санал тавьсан, буцаасан, саналаа тавиад буцаагаад л байсан. Найман удаа байх аа. Ингээд Ерөнхий сайдаа томилж чаддаггүй ээ. Зургаан сарын хугацаанд үүрэг гүйцэтгэх Засгийн газартай явлаа, парламент нь зун амарч чадаагүй юм. Ерөөсөө хаврын чуулган нь намартайгаа залгасан шүү дээ. Хамгийн харамсалтай нь Ерөнхий сайдад нэр дэвшүүлэхээр тохирсон хүнийг улс төрийн шалтгаанаар байх, амийг нь егүүтгэсэн. Ингээд аргагүйн эрхэнд, Монголын төр ийм байдлаар явах ямар ч арга алга боллоо. Тийм ч учраас намуудын хариуцлагыг дээшлүүлье, нэгэнт сонгогдсон бол үүргээ биелүүлье, дараа нь ард түмнээр дүгнүүлэг гэж Үндсэн хуульд аргагүй эрхэнд өөрчлөлт оруулсан юм. Одоо үүнийг өөрчилье гэвэл өөрчилж болно оо. Санал нэгтэй л байна. Би нэг их дэмжигч нь байгаагүй юм. Тухайн үед Энхбаяр, Гончигдорж хоёр хамгийн ахмад нь байсан учраас энд тэнд бичиг

өргөж барихдаа намайг дагуулж явдаг байсан. Би урд нь явдаг, нөгөө хоёр миний хойноос явдаг. Тиймэрхүү л процедур явсан байгаа юм. Засгийн газраа УИХ дотроос бүрэлдүүлчихдэг, нөгөөдөх нь сайд ч юм шиг, УИХ-ын гишүүн ч юм шиг, хуралдаа ч суух бололцоогүй ийм байдалд орчихсон шүү тээ. Өмнө нь 1992-1996 онд Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс илүүгүй нь парламентын гишүүн байж болно гэж хуульчилчихсан байсан. Тэр бол боломжийн байсан юм. Үүнийг цэгцлэх хэрэгтэй байх аа.

Үндсэн хуульд хуулиар зохицуулна гэсэн 238 заалт байдаг юм. Түүнээс нэг заалтыг нь одоо болтол биелүүлээгүй яваа. Тэр бол яам, агентлагийн статусын тухай хууль. Яагаад одоо болтол үүнийг шийдэж чадаагүй юм бэ гэвэл сонгууль болохоор нэг нам нь гараад ирдэг, өөрийнхөө хүнийг сайдаар тавимаар байдаг, сонгуульд нь оролцсон гээд элдвийн хүн байдаг болохоор орон тоо нэммээр байдаг. Дэд сайд байлгахаас өөр яахав. Яамны тоог нэмэхээс өөр яахав. Ингэсээр одоо болтол шийдэж чадаагүй явж байгаа шүү дээ. Тийм учраас Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг бүр Үндсэн хуульд хийгээд өгчих хэрэгтэй юм шиг байна. Тэгээд хэн гуай хэчнээн санал авна хамаагүй. Түүний дагуу л явна. Үүргийг нь Бямбасүрэн их зөв хэллээ. Утга учиргүй үүргийн хуваарь хийчихсэн гэж. Тэрийг цэгцэлж хэн юу хийхийг нь тодруулах шаардлага байгаа юм.

Сүүлийн жилүүдийн нэг том алдаа бол 2003 оноос эхлэн мөрдүүлсэн Төсвийн байгууллагын

удирдлага санхүүжилтийн тухай хууль байгаа юм. Энэ бол окустийн групп Монголын удирдлагын чадавхийг дээшлүүлэхийн тулд дэмжин тусалдаг орнуудаас 216 сая долларын буцалтгүй тусламж гарган Монголын 200 мянган залуусыг шинэ нөхцөл байдалд сургаж өгье гээд хэнд хэчнээн доллар хэзээ яаж гаргахыг бүгд тохирсон байсан. Тэгээд 1996 оны сонгуулиар унаад, тэгсэн чинь хэн нь хаанаас олсон юм Шинэ Зеландын Үндсэн хуулийг аваад зохиогоод оруулж ирсэн. Шинэ Зеланд бол колони орон. Төрийн тэргүүн гэж байхгүй. Английн томилсон хатан хаан төрийн хэргийг нь удирдаж явдаг. Тэгээд өөрөө колони маягийн орон учраас Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуулиа Шинэ Зеланд Үндсэн хууль гэж нэрлэдэг юм. Тэрийг манайхан хуулж авчираад Монголын Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хууль болгочихсон. Үндсэн хуультай 32 зүйлээр зөрсөн. Тэгээд тойруулсаар байгаад зөрчилгүй юм шиг дүр үзүүлээд л баталсан. Одоо газар сайгүй шүүмжлэл. Сумд ч эрх байдаггүй, аймагт ч эрх байдаггүй. Тэгээд бүтээгдэхүүн гээд нэг юм ярьдаг. Жишээлбэл, шоронгийн бүтээгдэхүүн гэж ямар юм байх юм. Бүү мэд. Наад зах нь. Ийм дампуу байдал руу орсон. Тийм учраас өөрчлөх ёстой хууль гэж бодож байна. Тэгээд Үндсэн хуульдаа хийх юм уу яах юм, санхүүгийн журмын тухай асуудлыг хуульчлах хэрэгтэй. Тэгэхгүй бол хэдэн төгрөг олдвол цацаад л байдаг. Олдохгүй бол хэрэлдээд суугаад байдаг. Ийм байдлаас бид гарахгүй байна.

Муу ч байлаа гэсэн зам, муухай ч байлаа гэсэн ээжээ гэж монголчууд ярьдаг. Тийм учраас парламентын засаглалын хэлбэрээс ухарч ерөөсөө болохгүй. Харин парламентын засаглалын хэлбэрийг жинхэнэ утгаар нь оруулах хэрэгтэй. Парламентын засаглалтай байж нийт ард түмнээс ерөнхийлөгчөө сонгодгийн утга байна уу. Түүний оронд парламентад олонх суудал авсан намын дарга нь Ерөнхий сайд байдаг бөгөөд тэр Ерөнхий сайдыг парламенттайгаа адил түвшинд тавьж болно. Тэгээд парламенттайгаа гар нийлээд ажиллалаа, гар нийлэхгүй бол Ерөнхий сайд өөрөө огцорно, эсвэл, Ерөнхий сайд парламентаа тараана. Парламентаа тараачихсан намын дарга, Ерөнхий сайдад дараачийн сонгуульд санал өгнө гэж хэзээ ч байдаггүй. Ингэж тэнцвэрээ барьдаг олон улсыг жишиг байна аа. Тийм учраас парламентын засаглалаа боловсронгуй болгож дэлхийн жишигт ойртуулж аваачих нь зүйтэй байх. Өнөөдөр бид жаахан бухимдалтай байна. 17 жил боллоо гэж зовж байгаа ч гэсэн энэ бол харьцангуй бага хугацаа. Манай төрийн тогтолцоо сайжрах байх, ард түмэн маань гэгээрэх байх, намууд маань төлөвших байх гэж бодож байна. Намуудаа төлөвшүүлэх, сонгогчдоо гэгээрүүлэх асуудал их чухал юм. Хээл хахууль энэ тэр гээд санал худалдаж авах явдал газар авсан. Үүнээс гарахын тулд өнөөдөр би ҮАБЗ цуглахын далимд хэлсэн байгаа. Болох нь уу, үгүй юү, мэдэхгүй. Ерөөсөө Монголыг таван тойрог болгочихъё. Дөрвөн бүс байгаа, түүн

дээрээ Улаанбаатараа оруулаад тав болно. Тэгээд таван тойрог болгож намууд дунд нь явахаар ядаж мөнгөөр хүний санал худалдаж авч дийлэхгүй шүү дээ. Бүсийн хөгжлийнхөө төлөө хүн юм боддог болох болов уу.

Д.Бямбасүрэн /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/
Миний дэвшүүлж буй саналыг хэлэлцэж өөрсдийнхөө саналыг нэмэрлэж байгаа Та бүхэнд баярлаж байна. Би Монголын төрийн тогтолцооны бүх асуудлыг хөндье гэж бодоогүй. Гэхдээ түүний гол зангилаа буюу суурь асуудал нь хаана байгаа гэдэг дээр төвлөрсөн. Бие биеэ ойлгох үүднээс хэдэн асуудал тодруульа гэж би бодож байна. Нэгдүгээрт нь, намын үүргийн тухай асуудал. Ардчилсан нийгэмд нам хэрэгтэй. Намгүй бол нийгэм өөрөө тэсрэлтэнд хүрнэ. Бослогод хүрнэ. Гэхдээ одоогийнх шиг ийм авангард намын суурин дээр бий болсон, хөрөнгө мөнгөний сүлбээнд оролцсон, хээл хахууль авилгалын мөнгөөр санхүүждэг улс төрийн намуудыг төрийн толгой дээр залаад явбал цаашид юунд хүрэх вэ гэдгийг бодож үзэх хэрэгтэй юм шиг санагддаг. Би намын үүрэг ролийг үгүйсгээгүй. Намууд сонгуульд ордгоороо л орно. Намын хажуугаар иргэний нийгэм ч орог. Ордог туршлага ч бий. Гэхдээ Үндсэн хуульдаа намыг хэтэрхий дээш нь гаргаад олонхийн суудал аваагүй, хамгийн олон суудал авсан нам хүртэл Засгийн газар байгуулдагийг эргэж харъя гэж хэлж байгаа юм. Тэр бодлогоо аваачаад Ерөнхийлөгчид тулгадаг.

Ерөнхийлөгч бол бүх ард түмнээс сонгосон субъект. Эрх зүйн чадамжийн хувьд Монголд хамгийн хүчтэй субъект нь Ерөнхийлөгч.

Сая Бадамдамдин гишүүн төр бол дарангуйллын зэвсэг юм гэж хэллээ. Энэ бол марксист ойлголт. Хэрэв нийгэм цогц нэгдлүүд л юм бол тэр цогц нэгдэхүүнд бий болсон нийтлэг асуудлыг бүх нийтийн эрх ашгийн үүднээс шийддэг төв зайлшгүй хэрэгтэй. Энэ бол ардчилсан нийгэмд төр гэж ойлгогдох байх. Тэр утгаараа төр нь чадварлаг байх зайлшгүй шаардлагатай. Би Ламжавын хэлдэгтэй санал нэг байна. Чингис хаанд зориулсан төр байгуулж ердөө болохгүй. Ард түмнээс сонгосон хэн ч гэлээ ирээд ажилладаг механизм байх хэрэгтэй. Ер нь намуудын хувьд бид ямаршуу асуудалтай байгааг одоо харж байгаа шүү дээ. Намуудад төлөвшил хэрэгтэй. Бид үүндээ шахалт өгөх хэрэгтэй. Тэгээд ч бусад орны туршлагыг харж байхад Ерөнхий сайдыг намтай зөвшилцөж томилно гэсэн заалт Германы Үндсэн хуульд ч байхгүй. Ганцхан Италийн Үндсэн хуульд олонхийн суудал авсан нам гэж байгаа.

Ерөнхийлөгчийн засаглалын хувьд онолын ойлголтын түвшинд парламент хуулиа тогтоогоод байж л байна шүү дээ. Хаант засаг бол хаан өөрөө хуулиа гаргадаг. Тийм болохоор огт өөр зүйлийн тухай асуудал юм. Одоо бид харж байгаа шүү дээ. Засгийн газрыг ямар хуйвалдаанаар, ямар хөрөнгө мөнгөөр байгуулж байна. Ер нь парламентаас Ерөнхийлөгчийг

сонгодог болбол тэр дундаас баян чинээлэг хүн гарч ирэхэд тун амархан болно. Тэгвэл бид үндэсний мөхөл рүүгээ явна.

Одоогийн төрийн тогтолцооны нөхцөлд нутгийнхаа 58 хувийг худалдчихаад бид өөр юуг худалдах гэсэн юм бэ. Үндэснийхээ хувь заяаг л худалдана биз дээ. Ийм асуудал руу явж болохгүй байх гэж бодож байна. Ард түмэн бүх нийтээрээ ерөнхийлөгчөө сонгодог нь Монголын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа гэж үздэг. Өөрөөр явбал бид их амархан Филиппиний гарт юм уу, эсвэл, Фридландын хармайнд ороод суучихна шүү дээ.

Төрийн тогтолцооны шинэчлэлийг яаж хийх вэ. Миний бодоход бүх нийтийн зөвшилд хэн нэгэн этгээд хүргэнэ гэвэл хэзээ ч бүтэхгүй. Үндсэн хуулийг өөрчлөх тухай асуудал байна. Хууль санаачлах эрхтэй гуравхан субъект байдаг. УИХ-ын гишүүн, Ерөнхийлөгч, Засгийн газар гэж. Хэрэв үнэхээр олон түмнийхээ санаа бодол, сэтгэлийн уур амьсгалыг бодитойгоор үнэлж үзэх чадвартай бол одоо Монголд ганцхан субъект л үүнийг хийж чадна. Ерөнхийлөгч Үндсэн хуулийг боловсронгуй болгох, баяжуулах, хөгжүүлэх асуудлаар комисс байгуулаад тэндээс гаргасан саналыг бүх ард түмнээр хэлэлцүүлэх асуудал байна. Түүнээс биш хэн нэгэн хүн, хэн нэгэн бүлэг хүмүүс Үндсэн хуулийг өөрчлөх гэж байна гээд сонин дээр тавиад олон түмнээр хэлэлцүүлж зөвшилд хүрэх механизм Монголд байхгүй. Гэхдээ би дахин хэлье. Би Ерөнхийлөгчийн засаглалын төлөө биш. Хэрэв одоогийн парламент дээр

ерөнхийлөгчид Засгийн газар байгуулах хариуцлагыг тохоод явбал Монголын төр дампууралд хүрнэ. Одоогийн парламентийг парламент гээд тэндээс ерөнхийлөгчийг сонгоод явбал Монгол улс үндэсний мөхөлд хүрнэ гэж би хэлж байгаа юм.

Цэцийн хувьд би санал нэг байна. Цэц бол шүүх хэвээрээ л байх ёстой. Харин парламентад санал дүгнэлтээ хүргэх дэд механизмын тухай асуудал байж болох л байх. Цэц одоо гурван янзын шийдвэр гаргаж байгаа. Бага суудал, дунд суудал, их суудлын шийдвэр гэж. Бага суудал, дунд суудлын шийдвэрийг парламент хэлэлцэж л байгаа шүү дээ. Бага, дунд суудлаараа иргэд нь гомдол тавиад ирвэл их суудлаараа хэлэлцэж эцэст нь шийддэг журам байвал шүүхийн чанар нь алдагдахгүй л болов уу. Тэртэй тэргүй УИХ-д няцаадаг нэг шат байгаа шүү дээ.

Ер нь цаашид төрийн тогтолцоог өөрчлөх асуудал нь онол, арга зүйн талаасаа, түүхэн талаасаа ч гэсэн асар их судалгаа шаардана аа. Үүнийг түр зуурын ажлын нэг бүлэг юм уу, эсвэл мэргэжилтнүүдийн бүлгээр шийдэж чадахгүй. Үүн дээр тогтвортой ажиллах бүтэц хэрэгтэй. Түүнийг би Төрийн судалгааны төв гэж нэрлээд байгаа юм. Үүнийгээ байгуулж чадвал болох л байх. Миний бодлоор одоо төрийн субъектүүдийн аль аль нь мөнгө санхүүгийн хувьд их боломжтой болсон юм шиг санагддаг. Үүн дээр анхаарвал болох байх.

Монголд ийм яриа их гарч байгаа. Бид эргээд социализм руугаа явчихлаа гэж. Бид социализм руу яваагүй. Харин капитализмын ялзрал руу яваад байна. Социализмд бид эргээд орж чадахгүй. Орох ч үгүй. Олон түмэн чинь ч үүнийг зөвшөөрөхгүй. Аль ч организмд тохиолдож болох өвчинд нэрвэгдээд тэр ялзрал руу л явж байгаа. Үүнээс гарах тухай л асуудал бий байх. Ухрах зам байхгүй.

Энэ бичсэн миний санаа бол өвгөн хүний сүүлчийн үг юм. Би өнгөрсөн жилийн тавдугаар сард “Төрийн доройтол, түүний ерөндөг” гэсэн өгүүлэл бичсэнээс хойш энэ сэдэв дээр чадах чинээгээрээ ажилласан. Улс төрийн хүчнүүд, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн байгууллагуудын хэн нь түүнээс боломжтой гэдгээ авч ашиглаж болно. Зохиогчийн эрх нь та бүхэнд шилжлээ гэж би бодож байгаа.

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Бидний яриа энэ хүрээндээ яригдаад дуусах гэж байна. Цаашид яах юм бэ. Цаашид улам дэлгэрүүлж, задалж, судлагдаж, ажил хэрэг болох замаар яваасай гэж хүсч байна.

Сая өвгөн миний сүүлчийн үг гэж мань хүн хэлж байна. Энэ сүүлчийн үг биш, үгийн чинь эхлэл болов уу гэж бодож байна. Бямбасүрэнгээс гадна янз бүрийн сонин санал ярьж байдаг хүмүүс их бий. Хуульчид ч бас энэ дээр янз бүрээр хандаж байгаа. Хэн

үүнийг барьж авч хийж чадах вэ гэдэг дээр ерөнхийлөгч гэж маш зөв хэллээ. Ерөнхийлөгч л санаачилгыг аваад аппарат байгуулах нь зүйтэй байх. Гэхдээ Төрийн судалгааны төв байгуулъя гэсэн санал зөв шиг байна. Төрийн судалгааны төвөө байгуулж төрийн тогтолцоог боловсронгуй болгох талаар хугацаатайгаар үүрэг өгч, хүмүүсийг томилон ажиллуулаач ээ гэсэн хүсэлтийг та бүхэн дээш нь хүргэнэ үү.

П.Эрдэнэжаргал /ННФ-ын Гүйцэтгэх захирал/
Арга зүй нь их чухал санагдаж байна. Тийм судалгааны төв байж болно л доо. “Үндэсний Хөгжлийн Хүрээлэн” гэсэн байгууллага байгаа шүү дээ. Тэр байгууллага сонгодог жишээ болох байх. Харин оролцоотой арга зүй нь хаа байна вэ? Энэ нь дутахаар буруу явчих тал бий. Тэгэхээр тийм төв байгуулъя гэвэл арга зүй буюу нийгмээ яаж идэвхтэй оролцуулах вэ гэдэг нь чухал юм.

Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/

Төв яах бол гэсэн болгоомжлол байна. Тийм ч юм байж магадгүй. Гэхдээ төв дээр энэ асуудлаа төвлөрүүлээд түүндээ янз бүрийн хүмүүсийг дайчилж болно. Хуульчдаа, иргэний нийгмийн төлөөлөө, бид нарыг ч гэсэн дайчилж болно оо. Ийм маягаар ерөнхийлөгчид хүсэлт тавивал яадаг юм бол. Үүнийг ерөнхийлөгч зохион байгуулсан нь дээр байх.

ГАРЧИГ

I. Ерөнхий хандлага	1
II. Нийгмийг бухимдуулж буй гажуудлууд	2
III. Гажуудлын үндэс	6
III.1. Төрийн бүрдэл	6
III.2. Төрийн үйл ажиллагааны хэлхээ	10
IV. Төрийн тогтолцоог төгөлдөржүүлэх үндсэн чиглэлүүд	21
Хэлэлцүүлгийн тэмдэглэл	29